

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2008-2012 ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

2010.12.24

Улиастай

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл	Хэрэгжилтийн байдал	Биелэлтийн хувь
<p><b>Эрхэм зорилго:</b> Улиастай хот болон сумдыг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангаж, хатуу хучилттай авто замын сүлжээнд холбох замаар ажлын байрыг нэмэгдүүлэн, ард иргэдийнхээ амьдралын түвшинг дээшлүүлж Завхан нутгаа хөгжүүлнэ.</p>			
<p align="center"><b>НЭГ. ХҮН АМ, ӨРХ ГЭР БҮЛД ЧИГЛЭСЭН НИЙГМИЙН ЗОХИСТОЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b></p>			
<p>Өрх гэр бүлийг дэмжин тэтгэх, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцлийг бүрдүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлсний үндсэн дээр хүний хөгжил, хүн амын өсөлтийг хангах нийгмийн таатай орчин бүрдүүлж, иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулна.</p>			
<p><b>1.1.ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГО</b> Хүн амд үзүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг, сургалт сурталчилгааг тогтмолжуулж, шинэ техник, тоног төхөөрөмжийг бүрэн ашиглах чадвартай мэргэжилтэй боловсон хүчнээр хангах нь тус салбарын үндсэн зорилт болно.</p>	<p>1.1.1. Хүн амын эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх сургалт сурталчилгааны ажлыг орон нутгийн онцлогт нийцүүлэн жил бүр тодорхой чиглэлээр зохион байгуулна.</p>	<p>Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд /2008-2010/ Хүн амын эрүүл мэндийг дэмжих, тэдэнд эрүүл мэндийн боловсрол олгох, олон нийтэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулах зорилтын хүрээнд “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай жигд хүргэе” сэдэвт бүсчилсэн уулзалт зөвлөлгөөн, Сумдын багийн бага эмч нарын “Эрүүл байхын төлөө хамтдаа”, “ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БАГТ ҮЗҮҮЛЭХЭД -БИДНИЙ ОРОЛЦОО” чуулга уулзалт,. Ерөнхий боловсролын сургуулиудын дунд эрүүл мэндийн уламжлалт олимпиад, “Эрүүл аж төрөхөд бидний оролцоо” уриан дор зохион байгуулан явуулж байна. Эх хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулах төслийг Завханхангай ОНХХ-тэй хамтран хэрэгжүүлж, гал голомт хөтөлбөрийн хүрээнд 950 сайн дурын ээжийг сайн дурын идэвхтэнээр бэлтгэж 20-26 нэр төрлийн хоолыг зааж сургасан. 2009 онд аймгийн Нэгдсэн эмнэлэгт Мэдээгүйжүүлэлт эрчимт эмчилгээ, Мэс засал, Халдварт, Мэдрэл, Хүүхдийн эмчийн чиглэлээр мэргэжил олгох сургалтанд 5 их эмчийг, 2010 онд Дотор, хүүхэд, мэдрэл, Дох/БЗДХ, эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр мэргэжил олгох сургалтанд сумын 9 их эмчийг, Зүрх судасны болон Дефлогографийн чиглэлээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2 их эмчийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн сургалтанд хамруулаад байна. Улиастай сумын Ган-оюу-жинст, Биндэргарав, Намчинманба, Надселманба, Дөрвөн оноо, Тосонцэнгэл сумын Энххөгжилнаран, Мөнхийн алба өрхийн эмнэлгүүдийн олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгаанд зориулж тус бүр 1 нийт 7 гэр барьж, тоног төхөөрөмжөөр ханган тохижуулсан.</p>	<p>90</p>

<p>1.1.2.Эмэгтэйчүүд, өсвөр үе, залуучууд зэрэг нийгмийн тодорхой бүлгүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох арга хэлбэрийг оновчтой болгож, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх боломжийг бүрдүүлнэ.</p>	<p>Хүн амын эрүүл мэндийг дэмжих тэдэнд эрүүл мэндийн боловсрол олгох, олон нийтэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах зорилтын хүрээнд 2009 оны үндсэн чиглэлд “Эхийн эндэгдлийг бууруулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж үр дүнг сайжруулна, сумдын ард иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулна. Вакцинжуулалтаар сэргийлэгддэг халдварт өвчнүүдийг багасгах зорилгоор урьдчилан сэргийлэх тарилганд бүх насны хүүхдийг хамруулж шаардлагатай сурвалжаар хангана 3 заалтыг оруулж биелэлтийн хүрээнд Баянтэс, Дөрвөлжин, Ургамал, Шилүүстэй, Идэр, Отгон, Их-Уул, Тосонцэнгэл, Эрдэнэхайрхан, Сантмаргац, Цэцэн-Уул сумдын ард иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 2450 иргэдийг хамруулсан. ДЗОУБ-ын санхүүгийн дэмжлэгтэй Эх хүүхдийн хоол тэжээлийн байдал, хяналтыг сайжруулж эндэгдэлийг бууруулъя сэдэвт зөвлөгөөн хийж зөвлөмж гарган 23 сум, бүх байгууллагуудад хүргүүллээ. Энэ зөвлөлгөөнд Завхан аймгийг хариуцсан мэргэжилтэн МУ-ын гавьяат эмч Б.Үйлст оролцов. Эхийн эндэгдлийг бууруулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж жирэмсэний хяналтын хөтөчийг 3000 хувь хэвлэж сумдад тараах, өндөр төрөлттэй Отгон, Тосонцэнгэл, Их-Уул, Баянтэс сумдын эх баригч нарыг Говь-Алтай аймгийн АУК-д мэргэжил дээшлүүлэх 14 хоногийн сургалтанд хамруулсан. Аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэд Хүүхэд өсвөр үеийн Ирээдүйн босго төвийг нээн үйл ажиллагаагаа явуулж ЕБС-ийн 7 сургууль, МСҮТ, ХБК-оос тус бүр 3 хүүхэд нийт 24 хүүхдийг үе тэнгийн сургагчаар бэлтгэв. Өсвөр үе-ирээдүйн босго төв нь ЭЗсС, МСҮТ, ЕБС-иудын эмч удирдлагуутай хамтын гэрээтэй ажилладаг. Улиастай, Тосонцэнгэл сумын ЕБС, ЭЗсС, ХБК-ын 10-19 настай 220 оюутан сурагчдаас Өсвөр үе нөхөн үржихүйн эрүүл мэнд, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг дадал, хандлагын судалгаа авч зөвлөлгөө өгсөн. ХБК-ийн 30, ЭЗсС-ийн-29, МСҮТ-ийн 135 оюутан 1,2,3,4-р сургуулийн-48, Тосонцэнгэл сумаас 1 хүүхэд охидын үзлэг шинжилгээнд, клиникийн үзлэгт 56 хүүхэд хамрагдсан. Нийт 365 өсвөр үеийнхэнд үзлэг шинжилгээ хийж зөвлөгөө өгөөд байна. Нэгдсэн эмнэлгийн дэргэд телемедицины кабинетыг байгуулан 1 их эмчийг бэлтгэн мэргэшүүлж үйл ажиллагаа явуулж эхлээд байна.</p>	<p>70</p>
<p>1.1.3.Гамшиг, гэнэтийн аюул осол, нийтийг хамарсан өвчлөлийн үед авах арга хэмжээний бэлтгэлийг хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	<p>Тарваган тахал болон Шувууны томуугийн үед авах арга хэмжээний төлөвлөгөө гарган, холбогдох зардалыг тооцон гаргаж төлөвлөсөн. Хүний томуугийн А хүрээний /H1N1/ вирусийн цар тахлын бэлэн байдлыг хангах тухай аймгийн ЭМГ-ын даргын 2009 оны 95 тоот тушаалыг гарган хэрэгжүүлж байна. Томуугийн А хүрээний /H1N1/ цар тахлын бэлэн байдлыг ханган ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөг томуугийн үед аймгийн хэмжээнд байж болох өвчлөлийн тоо 85836 хүн амд тооцон гаргасан. Бэлэн байдлыг хангах штабын бүрэлдэхүүний үүрэг, дуудан зарлан мэдээлэх схем, голомтонд ажиллах мэргэжлийн багийн бүрэлдэхүүн, мэргэжлийн багийн гүйцэтгэх үүрэг, томуугийн үеийн цар тахлын үеийн бэлэн байдлын тооцоог Улиастай сумын 24065 хүн амын 15%, 30%, 50%-ыг хамрах хүрээний үед авах арга хэмжээгээр тооцон төлөвлөгөөг гаргасан. Гамшиг, гэнэтийн аюул ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийж, бэлэн байдлыг үнэлсэн. “Томуугийн цар тахлын сургамж, цаашид авах арга хэмжээ үндэсний сургалтанд Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн, ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн дарга нар оролцсон. 2010 оны 10 дугаар сард зохион байгуулагдсан томуугийн цар тахлын VI зөвлөгөөнд аймгийн Тамгын газрын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ЭМГ-ын дарга, халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн, өрхийн эмнэлгийн ахлагч нар хамрагдаж, үндэсний хэмжээнд зөвлөмж гаргахад оролцсон.</p>	<p>70</p>
<p>1.1.4.Эмнэлэг, эрүүл мэндийн</p>	<p>Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Солонгос улсын Сөсан хотын тусламжаар 10 ш компьютер өгч,</p>	<p>90</p>

цахим мэдээллийн сан, алсын зайн оношлогоо эмчилгээг өргөжүүлж өвчнийг эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх чадавхийг дээшлүүлнэ.	бүх тасаг нэгжүүд цахим сүлжээнд холбогдсон. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн физик эмчилгээний аппарат хэрэгслийг шинэчилэн, амбулаторийн физик эмчилгээний кабинетэд Поток, УВЧ аппаратыг тавьж тогтмол үйл ажиллагаатай ажиллаж байна. Тосонцэнгэл сумын хожуулын амралтыг ахмадын сувилал болгон хөгжүүлж, Улиастай суманд “Зуун булаг” ахмадын сувилалыг шинээр байгуулан үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байна. Нөхөн сэргээх, уламжлалын чиглэлээр ажиллаж байгаа хувийн хэвшлийн болон төрийн эмнэлгийн үйл ажиллагааг дэмжиж, орчин үеийн тоног төхөөрөмжөөр ханган үйл ажиллагаа явуулж байна. 2009 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэргэд “Алсын зайн оношлогооны төвийг байгуулан, 2010 онд телемедицины кабинетыг нээн,эмч мэргэжилтэн, тоног төхөөрөмжийг үе шаттай бэлтгэж байна. 2010 онд Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 100,0 сая төгрөгний рентген аппаратыг суурилуулж өгсөн.	
1.1.5.Хөдөө орон нутгийн алслагдсан хүн амд үзүүлэх түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулж сумдын эмнэлгийн парк шинэчлэлийг үе шаттай хийнэ.	2008-2009 онд онд Аймгийн Нэгдсэн эмнэлэгт-3, Тосонцэнгэл сумын өрхийн эмнэлэгт-2, Нэгдсэн эмнэлэгт-1, Улиастай сумын 4 өрхөд 4 машин тус тус олгогдсон. Түдэвтэй сумын хүн эмнэлэгт Фурган машин, Асгат, Эрдэнэхайрхан, Сантмаргац сумын хүн эмнэлэгт түргэн тусламжийн УАЗ-469 автомашин, Цагаанхайрхан, Цагаанчулуут суманд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар фурган автомашин, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэгт Тогтвортой амжиргаа-II төслийн дэмжлэгтэйгээр автомашины парк шинэчлэлтийг хийсэн. Эрүүл мэндийн газарт ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар автомашин олгогдсон.	70
1.1.6.Жирэмсэн эмэгтэйчүүд, ураг нярай болон өсвөр насны охид, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгдмэл байдлыг хангасан цогц үйлчилгээг хэрэгжүүлнэ.	НҮБ-ХАС-ын санхүүжилтээр “Өсвөр үе-Ирээдүйн босго” төвийг Эрүүл мэндийн дэргэд байгуулан бага эмч-1, их эмч-1 ажиллаж байна. Энэ төвийг байгуулан Дэлхийн зөн ОУ-ийн байгууллагын “Завханхангай” ОНХХ, ЭМГ хамтран “Эх хүүхдийн хоол тэжээл” төслийг Канад улсын хөрөнгө оруулалттай 2 жил, “Эх хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах нь” төслийг Австрали улсын хөрөнгө оруулалттай Дэлхийн зөн ОУ-ийн байгууллагын “Завхан” ОНХХ 3 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр болж аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан, сумын Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн дарга, эмч, нийгмийн эрүүл мэндийн арга зүйч, эх баригч бага эмч нарыг оролцуулан 150 хүнд сургалтыг явуулж “Гал голомт хөтөлбөр” хэрэгжиж 0-5 насны хүүхдэд өгөх хоолыг зааж 950 сайн дурын ээжийг бэлтгэсэн	70
1.1.7.Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх ээлтэй орчин бүрдүүлнэ.	Дэлхийн зөн олон улсын байгууллагын санхүүжилтээр “Эх хүүхдийн эрүүл мэндийн чанарыг сайжруулах2 жилийн төслийг хэрэгжүүлж, энэ төслийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн 1 давхарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн “Нөхөн сэргээх төв”-ийг байгуулсан. Нөхөн сэргээх төвийг байгуулахад барилгын гадна дотор засварын ажилыг Ц.Жамьянсүрэн захиралтай Барилга худалдаа үйлчилгээний “Жавхлант Тур”ХХК нийт 34,461,944 ₮-ийн өртөгтэйгээр хийж гүйцэтгэсэн. Гадна талбайн хүүхдийн тоглоомыг “АМЭНАН ХХК”-аас 7,500,000₮ өртөгтэй суурилуулж өгсөн. Нөхөн сэргээх төвийн дотор болон гадна тохижилтийн нийт төсөв 30,000,000-д Нийт 71,961,944₮ төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олон нийтийн оролцоонд түшиглэсэн хөдөлмөр халамж үйлчилгээний үйлчилгээг, хувийн хэвшил аж ахуйн нэгжүүд хүргэж байна.	90
1.1.8.Эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг тогтмолжуулж, багийн эмчийн эмийн нөөцийг	Аймгийн Засаг даргын захирамжаар хөдөөгийн 88 багийн эмчид 1 бүр 100,0/зуун/ мянган төгрөгний 40 нэр төрөл бүхийн эм бэлдмэлийн эргэлтийн эмийн санг олгож, эргэлтийн эмийн сантай болгосон. 2010 оны 7 дугаар сард үйл ажиллагаанд үнэлгээ хийхэд 140-200,0/ зуу/	70

нэмэгдүүлнэ.	мянган төгрөгний санхүүгийн нөөцөд эргэлдэж байна. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд сумын эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх заалтыг тусган хэрэгжүүлж, ЭМШУИС-ийн мэргэжлийн багш наран “Эмийн зохистой хэрэглээ” сургалтыг явуулж байна.	
1.1.9.Эрүүл мэндийн байгууллагуудыг нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнээр хангаж тогтвор сууршилтай ажиллуулан гадаад, дотоодод бэлтгэн мэргэшүүлнэ.	2009онд Аймгийн Нэгдсэн эмнэлэгт мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээ, мэс засал, халдварт, мэдрэл зэрэг төрөлжсөн нарийн мэргэжлийн резидентурын сургалтанд 8 их эмчийг, 2010 онд Дотор, хүүхэд, мэдрэл, Дох/БЗДХ, эх барих эмэгтэйчүүдийн чиглэлээр мэргэжил олгох сургалтанд 9 их эмчийг , Зүрх судасны болон Дефлогографийн чиглэлээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2 их эмчийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн сургалтанд хамрууллаа. 2009 онд Аймгийн эрүүл мэндийн салбарт 20-оос дээш жил ажиллаж байгаа их эм зүйч 15 хүнийг тус бүр 300000 төгрөгөөр, дадлагажигчаар ирж ажиллаж байгаа 11 их эмчийг тус бүр 50000 төгрөгөөр шагнаж урамшуулсан байна “Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах “ чиглэлээр Өрхийн эмч Н. Сайнбилэгийг Япон улсад 1 сарын сургалтанд явуулсан. Түдэвтэй СДЭ-ийн эрхлэгч эмч Б.Лхам-эрдэнийг ЭМСХ-2 төслийн хүрээнд Вьетнам улсад танилцах аялалд 14 хоног явуулсан.	70
1.1.10.Сумын хүн эмнэлгийг их эмчээр бүрэн хангаж, стандартын түвшинд ойртуулах зорилгоор анагаахын сургуулиудад суралцаж буй оюутнуудтай гэрээ хийж, цаашид 2 эмчтэй болгох нөхцлийн эхлэлийг тавина.	Алдархаан суманд их эмч Төмөрбаатар,Цагаанхайрхан суманд их эмч Нямсүрэнг томилон ажиллуулж, Шилүүстэй суманд их эмч Я.Болороо, Сантмаргац суманд их эмч Хишигжаргал нарыг 1-3 жилийн хугацаатай гэрээ хийж жил бүр 1 сая төгрөгний урамшуулал өгч ажиллуулсан. Хөдөөгийн болон өрхийн эмнэлгүүдийг 2 их эмчээр хангаж, 1 их эмчтэй ажиллаж байгаа Цэцэн-уул Нөмрөг, Завханмандал, сумдыг 2011 онд эмчтэй болгоно.	90
1.1.11.Сумдын эмнэлгийг оношлогоо , эмчилгээ , сувилахуйн орчин үеийн багаж, тоног төхөөрөмж, зориулалтын ор болон хэрэгслэлээр хангах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.	Аймгийн эдийн засаг ,нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, Аймгийн нэгдсэн эмнэлэгт 1.560.000 төгрөгний 30 ор хэрэгсэлээр, Шилүүстэй сум дундын эмнэлэгт 1.040.000 төгрөгний 20 ор хэрэгсэлээр хангасан. ДЗОУ-ын байгууллагаас: -Аймгийн 24 суманд амбу, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг, Идэр, Сантмаргац, Баянтэс, аймгийн Нэгдсэн эмнэлэгийн хүүхдийн тасаг тус бүр нэг хүчилтөрөгч өтгөрүүлэгч -Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх кабинет, Тэс суманд Эхо аппарат -Аймгийн НЭ-ийн төрөх тасагт нярайн дэлгэц, дулаацуулах ор, Их-уул суманд нярайн дулаацуулах ор ,автоклавы -Аймгийн НЭ-ийн нүдний кабинетэд нүдний биомикроскоп -Их-уул, Тосонцэнгэл , Нөмрөг сумдад Отсос - Аймгийн НЭ.Тосонцэнгэлийн НЭ-т тус бүр бактерицидины ламп -Аймгийн НЭ-ийн төрөх тасагтмэс заслын ор , зөөвөрийн ор, тэргэнцэр тус тус олгосон. 2010 онд Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган оруулж, Шилүүстэй сумын вакцины өрөөг орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангаж, тохижуулсан.. Сумдын эмнэлгүүдэд компьютер, принтер, эхо, Тосонцэнгэл сумын нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны 100,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар рентген аппаратыг суурилуулж өгсөн.	70
1.1.12.Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэн бүр жилд нэг удаа нарийн мэргэжлийн эмч	Төрийн цогц үйлчилгээг багт хүргэх ажлын хүрээнд хөдөөгийн 88 багт төрийн үйлчилгээг газар дээр нь үзүүлэх багийн бүрэлдэхүүнд нарийн мэргэжлийн багийг ажиллуулж, хөдөөгийн давхардсан тоогоор 8500 иргэдэд дотор, эхо, шүд, эмэгтэйчүүд, уламжлалын	70

<p>нарын үзлэг оношлогоог үнэ төлбөргүй хийлгэх боломжийг бүрдүүлнэ.</p>	<p>чиглэлээр эмнэлгийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн.Сайн дурын зөвлөгөө шинжилгээнд 354 хүнийг хамруулж сургалт зохион байгуулсан. Дээрхи үзлэг, оношилгооны үр дүнд элэгний хавдар, сүрьеэ, өсөлтгүй жирэмсэн зэргийг шинээр илрүүлэн, зөвлөгөө өгч 2 дугаар шатлалын эмнэлэгт илгээсэн.</p>	
<p>1.1.13.Багийн эмч нарыг аль ч улирлын нөхцөлд ашиглах боломжтой унаа хөсгөөр хангана.</p>	<p>2009 онд сумдын багийн бага эмчийг унаажуулахад зориулж 3.5 сая төгрөгийг гаргаж, Тэс суманд-1, Баянтэс-3 Баянхайрхан-2, Асгат-1, Нөмрөг-2, Түдэвтэй-1, Тэлмэн-2, Цэцэн-уул-2 тус тус морины үнэ олгосон. 2010 онд Тосонцэнгэл сумын Рашаант, Баян-улаан баг,Асгат сумын Аргалант баг, Баянхайрхан сумын Минж багт-1, Идэр смуын Дархан-уул багт-1, Их-уул сумын Цэцүүх баг, Нөмрөг сумын Дархан-уул баг, Тэс сумын Тооно багт , Тэлмэн сумын Баянтэгш баг, Цагаанхайрхан сумын Баянбулаг, Цагаанчулуут сумын Арц, Цэцэн-уул сумын Сангийн далай, Шилүүстэй сумын Хөгжил, Эрдэнэхайрхан сумын Баянзүрх, Яруу сумын Зүйл багийг эмчнарт морь, Дөрвөлжин сумын Онц баг, Ургамал сумын Тосгуур багийн эмчид туё бүр тэмээ, Баянтэс сумын Жавхлан баг, Завханмандал сумын Олонтүрүү баг, Отгон сумын Онц , Сантмаргац сумын Онц, Сонгино сумын тариат, Түдэвтэй сумын Баянцагаан, Сант сумын багийн эмчнарт тус бүр мотоциколь нийт 14 морь,2 тэмээ, 8 мотоциколийн үнийг олгосон.</p>	70
<p>1.1.14.Аймгийн нэгдсэн эмнэлгийг Оношлогоо-эмчилгээний төв болгон өргөтгөж цахим сүлжээг нэвтрүүлэн, дурангийн мэс заслын мэргэжилтнүүдийг бэлтгэн хагалгааг хийх нөхцлийг бүрдүүлж, Рашаан сувилал уламжлалт анагаах ухааны нэгдсэн төвийг баруун бүсийн эмчилгээний төв болгон өргөжүүлнэ.</p>	<p>Аймгийн Нэгдсэн эмнэлэгт “Алсын зайн оношлогооны” төвийг нээж үйл ажиллагаа тогтмол явагдаж байна. Нэгдсэн эмнэлэгт дурангийн аппаратыг суурилуулж, эмч, сувилагчийг мэргэшүүлэн ажиллуулаад байна. Мөн дурангийн мэс заслын эмч бэлтгэх 10 хоногийн сургалтанд аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын их эмч У.Оргилыг хамруулж бэлгэсэн. Рашаан сувилал уламжлалт анагаах ухааны нэгдсэн төвийг баруун бүсийн төв болгон хөгжүүлэх зорилгоор үе шаттай арга хэмжээг явуулж байна. Даатгалын санхүүжилтийг нэмэгдүүлсэн, зуны улиралд баруун 5 аймгийн амрагчдыг хүлээн авч амрах, сувилуулах үйл ажиллагааг явуулж байна.</p>	70
<p>1.1.15.Аймгийн төвд 30 ортой Халдвартын, Шилүүстэй суманд 20 ортой эмнэлэг барьж, Гоц халдварт, Цагаанхайрхан, Отгон, Идэр сумдын хүн эмнэлгийн барилгыг дуусгаж ашиглалтанд оруулна.</p>	<p>2009 оны үндсэн чиглэлд тусган оруулж, Байгалийн голомтод халдварт өвчинтэй тэмцэх газар, Цагаанхайрхан, Отгон сумдын эмнэлгийн барилгын ажил дуусаж ашиглалтанд орсон. Шилүүстэй сумын 20 эмнэлгийн барилга, Идэр сумын эмнэлгийн барилгын ажил явагдаж байгаа. Халдвартын 30 ортой эмнэлгийн барилгын төсвийг 2011 оны төсөвт оруулна.</p>	70
<p>1.1.16.Өрхийн эмнэлгүүдийн бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгож, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд зориулж, Тосонцэнгэл сумын 2 өрхийн, Улиастай сумын 4 өрхийн эмнэлэгт машин олгосон. Улиастай, сумын Медакаль, Биндэргарав, Намчинманба, Надсэлманба, Дөрвөн оноо, Тосонцэнгэл сумын Энххөгжилнаран, Мөнхийн алба өрхийн эмнэлгүүдийн үйл ажиллагаанд зориулж Засаг даргын нөөц сангаас тус бүр 100.0 /нэг зуун мянган/ төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Өрхийн эмч нарын баруун бүсийн чуулга уулзалтыг зохион байгуулж Засаг даргын нөөц сангаас 300,0 /гурван зуун/ мянган төгрөгний дэмжлэгийг үзүүлсэн. Улиастай сумын Биндэргарав өрхийн эмнэлэгийн халаалалтын шугаманд засварын ажлыг хийж өгсөн.</p>	50

		Улиастай сумын Ган-оюу-жинст, Биндэргарав, Намчинманба, Надсэлманба, Дөрвөн оноо, Тосонцэнгэл сумын Энххөгжилнаран, Мөнхийн алба өрхийн эмнэлгүүдийн олон нийтэд чиглэсэн сургалт сурталчилгаанд зориулж тус бүр 1, нийт 7 гэр барьж, тоног төхөөрөмжөөр ханган тохижуулж өгсөн.	
	1.1.17.“Отгонтэнгэр” рашаан сувилалын байр болон зарим сумдын хүн эмнэлгийн барилгыг үе шаттайгаар засварлаж, эмчийн байргүй сумдыг байртай болгоно.	2009 оны Үндсэн чиглэлд тусган оруулж, “Отгонтэнгэр” рашаан сувилалын байрыг засварлаж дууссан. Сантмаргац, Цэцэн уул сумын эмчийн байр, машины гражийг барьж ашиглалтанд оруулсан. 2010 онд Эрдэнэхайрхан, Алдархаан сумдын эмнэлгийг засварлаж, Баянхайрхан, Сонгино сумын эмнэлгийн халаалтын зуухыг шинэчилсэн.	70
	1.1.18.ОХУ-ын Тыва улстай эмч мэргэжилтнүүдийг солилцон ажиллуулахын зэрэгцээ эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг бэлтгэх ажлыг эхлүүлж, ард иргэдийг тус улсад оношлогоо, эмчилгээ хийлгэх нөхцөл бололцоог бүрдүүлнэ.	Эрүүл мэндийн чиглэлээр оюутан суралцуулах, солилцох талаар ОХУ-ын БНТыва улсын Засгийн газрын тэргүүн Кара-оол Шалбан Вальевич тай хийсэн гэрээнд тусгасан. Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, орлогч дарга нар БНТува улсад очиж, эмнэлгийн үйл ажиллагаатай танилцан, туршлага судлаж ирсэн.	50
<b>БИЕИЙН ТАМИРЫН БОДЛОГО</b> <b>Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, багш дасгалжуулагчдын ур чадварыг дээшлүүлж тив дэлхийд өрсөлдөх тамирчдын залуу</b>	1.1.19.Спортын иж бүрэн цогцолбор ордныг барьж ашиглалтад оруулна.	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд заалтыг тусган оруулж, Спортын барилгын өргөтгөлийн барилгын ажлыг Эрдэнэт хотын Мөнхжаргал захиралтай “БЯЦО” ХХК гүйцэтгэж ашиглалтанд өгсөн. 2010 онд спортын газрын дээврийн засварын ажлыг “Зуурмаг” ХХК хийж гүйцэтгэсэн.	70
	1.1.20.Биеийн тамир спортын уралдаан тэмцээн явуулах, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх иж бүрэн талбай байгуулна.	Улиастай суманд Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэн байгуулахаар Богдын гол багийн Чигэстэй голын дагуу 0.2 га газрыг хамгаалалтанд авч зураглалын хийн 1200 модыг тарьсан. Дэлхийн зөн олон улсын байгууллагын 55.000 ам \$-ын санхүүжилтээр хүүхэд залуучуудын соёл амралтын талбайд 18.5 ам \$-ын тоглоом нийлүүлж байгуулагдан ажиллаж байна. Товцог, Өлзийт, Жаргалант, Чигэстэй, Богдын гол багуудад хүүхэд залуучуудад зориулан сагсан бөмбөг, мөсөн гулгуурын талбайг арван долоон сая /17.0/ төгрөгөөр, фитнес клубыг дөчин гурван сая /43.0/ төгрөгийн санхүүжилтээр байгуулан ажиллаж байна.	90
	1.1.21.Аймгийн Засаг даргын	Аймгийн Биеийн тамир спортын газрын дэргэд хөдөө сумдаас 8-10 насны хүүхдүүдийг	70

<p>халааг бэлтгэх нь тус салбарын гол зорилт болно.</p>	<p>ивээл дор спортын 8 хүртэл төрлөөр хүүхдийн шигшээ баг байгуулж сургалт дасгалжуулалтыг сайжруулна.</p>	<p>сонгон шалгаруулж, чөлөөт, жү-до бөхийн өдөр өнжүүлэх бүлэг нээн хичээллэж байна. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 2 заалтыг тусган оруулж “Хаврын баяр -2009” спортын наадмыг үндэсний спортын 8 төрлөөр зохион байгуулж Засаг даргын нөөц сангаас гурван сая /3.0/ төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. “Алтан намар” хүүхдийн спортын наадам орон нутгийн төсөв хасагдсан учир энэ арга хэмжээг явуулаагүй. Биеийн тамир спортын дэргэд 8-10 насны хүүхдүүдийн Самбо, Жүдо бөхийн өдөр өнжүүлэх анги нээгдэн хичээллэж байна. Монголын Баруун бүсийн Их дээд сургууль, коллежийн оюутаны биеийн тамир, урлагийн 12 дугаар их наадмыг 10 дугаар сарын 6-9 ны өдрүүдэд зохион байгуулж, Ховд БИС, ХААИС, Архангай БИС, Увс аймгийн Улаангом коллеж, Говь-алтай аймгийн Анагаах ухааны коллеж, Хөвсгөл аймгийн Далай ван коллежийн оюутанууд оролцож, Спортын 5 төрөл, Дэвжээ, Эрдэм шинжилгээний бага хурал ыг зохион байгуулсан. Энэ үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын Тамгын газраас 1.000.000 / нэг сая / төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>-Мянганы замаар 1000 км зам туулах Хөдөлмөрийн баатар Ш.Отгонбилэгийн нэрэмжит “СПОРТ ЭРҮҮЛ МЭНД- ЭРҮҮЛ БАЙГАЛЬ, САРУУЛ УХААН” сэдэвт явган аяллын багийхан Завхан аймгийн Улиастай хотоос 5 дугаар сарын 1 нд гараагаа эхэлсэн. Багийханд Аймгийн Засаг даргын нөөц сангаасаа таван зуун мянган төгрөгийг /500.000/ дэмжлэг үзүүлсэн. Биеийн тамир спортын газрын дэргэд секц дугуйлан хичээллэж, 2009 онд Улсын Өсвөр үе, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд цана, жү-до, самбо, 100 буудалт даам, хүчний 3 төрлөөр оролцож алт мөнгө, хүрэл медаль авсан 14 тамирчин 6 дасгалжуулагчийг аймгийн Засаг дарга нөөц сангаасаа 685,0 /зургаан зуун наян тав/ мянган төгрөгийг гаргаж шагнаж урамшуулсан,</p>	
<b>ДҮН</b>			<b>72,9</b>
<p><b>1.2. БОЛОВСРОЛЫН БОДЛОГО</b> Боловсролын байгууллагын бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгож, багш нарын хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэн мэргэжлийн чадавхийг дээшлүүлж, сургалтын орчинг сайжруулах замаар иргэдэд үзүүлэх боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх явдал энэ салбарын гол зорилт болно.</p>	<p>1.2.1.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүтэц, зохион байгуулалт, байршлыг оновчтой болгон, бүсийн түшиц болон цогцолбор сургуулиудыг дэмжих чиглэл баримталж, ЕБС-ийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, суурь боловсролын насны хүүхдийн хамран сургалтыг 99.0 хувьд хүргэнэ.</p>	<p>Цогцолбор болон бүсийн түшиц сургуулийг түлхүү дэмжих чиглэл баримтлан Шилүүстэй, Завханмандал, Сантмаргаз сумдын сургуулийн хичээлийн болон дотуур байранд иж бүрэн засвар хийж, Их-Уул, Тосонцэнгэл, Түдэвтэй сумдад хичээлийн байр шинээр барьж байна. ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж, 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, сургууль завсардалтыг зогсоосноор суурь боловсролын хамран сургалтыг 98.0 хувьд хүргэсэн байна. Бүсийн түшиц сургуулиар Чандмань эрдэнэ цогцолбор, Тосонцэнгэл I, Шилүүстэй, Завханмандал, Сонгино, Баянтэс сумдын сургуулийг сонгон шалгаруулж Японы Олон Улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага JICA–гийн шугамаар хэрэгжиж буй “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл”-д хамруулж байна.ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулснаар 1,2,3,8–р анги 12 жилийн сургалтын хөтөлбөрөөр, 7-р анги шилжилтийн, бусад ангиуд 11 жилийн сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байна. 6 настай 1254 хүүхдийг шинээр элсүүлсэн.</p>	70
	<p>1.2.2.Малчдын хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг ойртуулах зорилгоор багуудад гэр цэцэрлэг байгуулж, СӨБ-ийн хамран сургалтыг 70.0 хувьд хүргэнэ.</p>	<p>Аймгийн хэмжээнд СӨБ-ын насны 5382 хүүхэд байгаагийн 3488 нь цэцэрлэгт хамрагдаж 64.8 хувь, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг малчдад ойртуулах зорилгоор ээлжийн бүлэг, нүүдлийн бүлэг, гэр цэцэрлэг ажиллуулах замаар 1060 хүүхдийг хамруулснаар СӨБ-ын хамран сургалт 84.5 хувьтай байна. СӨБ-ын насны хүүхдээс цэцэрлэгт 3813, хувилбарт сургалтанд 1293 хүүхэд хамрагдсан байна.</p>	90
	<p>1.2.3.Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгийг шинээр</p>	<p>Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг бүх талаар дэмжин Улиастай сумын Тэгш хэм сургуулийг түшиглэн Спортын өдөр өнжүүлэх бүлэг хичээллүүлж эхлээд</p>	70

үүсгэн байгуулах санаачилгад дэмжлэг үзүүлнэ.	байна. Тосонцэнгэл сумын Симба, Баянтэс сумын Гэгээ хувийн хэвшлийн цэцэрлэгт 72 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна. Улиастай сумын Дэвшил сургууль татан буугдаж, Тосонцэнгэлийн Симба цэцэрлэг төрийн өмчид шилжиж, одоо Баянтэс сумын Гэгээ цэцэрлэгт 26 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна. Одоогоор хувийн сургууль, цэцэрлэг шинээр байгуулах талаар ямар нэг санал ирээгүй байна.	
1.2.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулж, нийгэмшүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгэм хамт олны дунд боловсролд тэгш хамруулах чиглэл баримталж байна. 2009 оны байдлаар аймгийн ЕБС-дад хөгжлийн бэрхшээлтэй 792 хүүхэд хамрагдаж байгаагийн 352 нь харах эрхтний, 149 сонсох эрхтний, 135 нь хэл ярианы, 35 оюун ухааны, 84 бие эрхтний, 37 нь хавсарсан хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцаж байна. Аймгийн ЕБС-иудад хөгжлийн бэрхшээлтэй 676 хүүхэд хамрагдаж байгаагийн 334 нь харах эрхтний, 91 сонсох эрхтний, 115 нь хэл ярианы, 24 оюун ухааны, 87 бие эрхтний, 25 нь хавсарсан хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцаж байна. СӨБ д хөгжлийн бэрхшээлтэй 20 хүүхэд хамрагдаж байгаагийн 2 нь харах эрхтний, 2 сонсох эрхтний, 2 нь хэл ярианы, 2 оюун ухааны, 9 бие эрхтний, 3 нь хавсарсан хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүд суралцаж байна.	90
1.2.5.Албан бус боловсролын "Гэгээрлийн төв" -үүдийг сургалтын тоног төхөөрөмжөөр ханган, үйл ажиллагааг нь өргөжүүлэн, иргэдийн хэрэгцээ сонирхолд тулгуурласан уян хатан үйлчилгээг бий болгоно.	Албан бус боловсрол зайн сургалтын 24 сумын гэгээрлийн төвүүдэд Адра ОУ-ын байгууллага, Дэлхийн зөн ОУ-ын байгууллага Аймгийн ЗДТГ, Албан бус боловсрол, зайн сургалтын үндэсний төв зэрэг байгууллагуудаас дараах тоног төхөөрөмжүүдийг олгосон байна. Оёдлын машин 10 ш, DVD тоглуулагч 5 ш, ноос самнах машин 2 ш, үсчний хэрэглэл 3, Тогооч бэлтгэх сургалтын тоног төхөөрөмж 1, нарийн боовны төхөөрөмж 5 ш, модны суурь машин 2 ш, гарын авлага сурах бичиг 39, сургалтын видео хичээл 115, сургалтын хөтөлбөр 33. Үүний үр дүнд Албан бус боловсролын гэгээрлийн төвүүд амьдрах ухааны сургалт явуулах бүрэн нөөц боломжоор хангагдсан байна. Адра ОУ-ын байгууллагын "Боловсрол" төсөл, Албан бус боловсрол, зайн сургалтын үндэсний төв зэрэг байгууллагуудаас 20,0 сая төгрөгний санхүүжилт бүхий Завханмандал, Эрдэнэхайрхан, Яруу, Улиастай сумын 3 сургууль, Идэр сумуудын "Гэгээрлийн төвүүдэд иж бүрэн компьютер, тоног төхөөрөмж, сурах бичгийг олгосон байна. АДРА ОУБ-ын санхүүжилтээр албан бус боловсролын 8 арга зүйчдэд сургалт зохион байгууллаа.	90
1.2.6.Архангай аймаг дахь Багшийн коллежтой хамтран бага ангийн багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлж, дипломын боловсролтой бага ангийн багш нарыг бакалаврын боловсролтой болгоно.	Аймгийн хэмжээнд бага ангийн 304 багш ажиллаж байгаагийн 88 нь дипломын боловсролтой байсан байна. 2008-2009 онд тэдгээр багш нарыг Архангай аймаг дахь Багшийн коллежтой хамтран бакалаврын боловсрол олгох сургалтанд хамруулснаар 49 нь төгссөн байна. Мөн өөр мэргэжлийн багш нараас 8 багш бага ангийн багшаар бэлтгэгдэн ажиллаж байна. Хүмүүнлэгийн ухааны их сургуультай хамтран магистрийн сургалтыг орон нутагтаа зохион байгуулж 68 багшийг хамруулж магистрын зэрэгтэй багш нарын тоог нэмэгдүүллээ.	100
1.2.7.ОХУ-ын Тыва Улсын боловсрол, соёлын байгууллагуудтай шууд харилцаа тогтоож, харилцан туршлага солилцох, мэргэжил дээшлүүлэх, соёл урлаг-спортын өдрүүдийг зохион байгуулна.	ОХУ-ын Тыва Улсын Ерөнхийлөгч Каро-Оол Шолбан Валеривич аймгийн Засаг даргын урилгаар Завхан аймагт ажлын айлчлал хийж, хоёр талын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурснаар нэг хэсэг зогсонги байдалд ороод байсан Боловсрол, соёлын салбарын хамтын ажиллагааны эрх зүйн орчин бүрдээд байна. Гэрээнд тусгагдсанаар оюутан солилцох,багш нарын мэргэжил дээшлүүлэх, Соёлын өдрүүдийг Кызыл, Улиастай хотод ээлжлэн зохион байгуулах зэргээр хамтран ажиллах юм.	30
1.2.8.Боловсролын	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ЕБС-иуд мэргэжлийн багшаар бүрэн	90

	байгуулагуудыг мэргэжлийн багшаар бүрэн хангаж, тэднийг гадаад, дотоодын сургалтанд хамруулж, орчин үеийн мэдээлэл харилцааны технологийг эзэмшүүлнэ.	хангагдсан байна. 2009 онд мэргэжил дээшлүүлэх сургалтанд 1016 багш хамрагдсан нь нийт багш нарын тоонд харьцуулахад 114.8 хувьтай байна. Аймгийн хэмжээнд 3 удирдах ажилтан, багш нар гадаад оронд туршлага судлах аялалд оролцсон байна. Энэ хичээлийн жилд ЕБС-д 873, СӨБ-д 142 багш ажиллаж байна. Төвлөрсөн болон орон нутгийн сургалтанд ЕБС-ийн 667, СӨБ-ын 98 багш хамрагдаж гадаадад 6 багш мэргэжлээ дээшлүүлсэн байна. ЕБС-ийн багш нарын хангалт 100%, Сургуулийн өмнөх боловсролын багш нарын хангалт 98,8% байна. Багш нарт орчин үеийн мэдээлэл харилцааны технологийг эзэмшүүлэх зорилгоор Цахим сургууль аяныг зарлан дүгнээд байна.	
	1.2.9. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг зөөврийн компьютертэй болгож, ерөнхий боловсролын сургуулийн нэг компьютерт ноогдох хүүхдийн тоог 2 дахин багасгана.	Ерөнхий боловсролын сургуулиудад Гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр, төсвийн хөрөнгө болон хандиваар компьютер нийлүүлснээр 412ш компьютертэй болж, нэг компьютерт ноогдох хүүхдийн тоо 41 болсон нь өмнөх оноос 19-өөр буурсан байна. Багш нарыг зөөврийн компьютертэй болгох асуудлыг судалж байна. Ерөнхий боловсролын сургуулиудад гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр, төсвийн хөрөнгө болон хандиваар компьютер нийлүүлснээр 698 ш компьютертэй болж, нэг компьютерт ноогдох хүүхдийн тоо 22 болсон нь өмнөх оноос 19-өөр буурсан байна. “Сайн компьютер” худалдааны байгууллагатай хамтран лизингээр багш нарыг зөөврийн компьютертэй болгох асуудлыг шийдвэрлэж байна. Үр дүнд түргэн хүрэх санаачлага түншлэл” хөтөлбөрийн хүрээнд Чандмань-Эрдэнэ, Тосонцэнгэл сумын II сургуулиудад “Мэдээлэлийн технологийн төв” нийлүүлээ. Отгон, Яруу, Сантмаргаз, Улиастай VIII цэцэрлэгт багш нарын тоогоор 14 компьютер нийлүүлээ.	70
	1.2.10. Ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн байрын 30-аас доошгүй хувийг засварлаж, 20-оос доошгүй хувийг шинээр барих асуудлыг ээлж дараатай шийдвэрлэнэ.	Тосонцэнгэл сумын I сургуульд 640 хүүхдийн, Түдэвтэй, Их-Уул суманд тус бүр 320 хүүхдийн суудалтай хичээлийн байрыг барьж эхлээд байна. Эрдэнэхайрхан сумын спорт заалны барилгыг барьж дуусгах, Сантмаргаз, Идэр, Нөмрөг, Яруу сумдын хичээлийн байр, спорт заалны засварт нийт 829,9 сая төгрөгийн засварын ажил хийгдэж ашиглалтанд орсон байна. Их-Уул суманд 320 хүүхдийн суудалтай хичээлийн байрыг барьж ашиглалтанд өглөө. Тосонцэнгэл сумын 1 сургуулийн 640 хүүхдийн, Түдэвтэй сумын 320 хүүхдийн хичээлийн байр, Дөрвөлжин сумын сургуулийн дотуур байр баригдаж байна. Эрдэнэхайрхан сумын 160 хүүхдийн хичээлийн байр Японы “Өвсний үндэс” хөтөлбөрийн санхүүжилтээр засварлагдаж байна.	90
	1.2.11. Сургууль, цэцэрлэгүүдийн барилга, дотуур байр, гал тогоог тохижуулж, хүчин чадлыг нь нэмэгдүүлэн, “Үдийн цай хоолны цех”-ийг ээлж дараатайгаар байгуулна.	2009 онд Сантмаргаз, Тэс, Шилүүстэй сумдын дотуур байранд засвар хийж, Улиастайн IY, Эрдэнэхайрхан, Их-Уул, Цэцэн-уул, Сантмаргац, Сонгино сумдын сургууль шинээр “Үдийн цай-хоолны цех” тэй болсон байна. Хичээлийн 5 өдрийн 2 өдөрт нь халуун хоолоор үйлчилж эхэлснээр Үдийн цайг Үдийн хоол болгох эхлэл тавигдлаа. Улиастай сумын Чигэстэй багийн VIII, Жинст багийн I, Отгон, Сантмаргац, Яруу сумын хүүхдийн цэцэрлэгүүдийг 11,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар, Улиастай сумын 3-р сургуулийг Дэлхийн зөн ОУБ-тай хамтран 1,3 сая төгрөгний гал тогооны иж бүрэн цахилгаан хэрэгслээр хангалаа. Баянхайрхан сумын сургуулийн гал тогоо, дотуур байранд их засвар хийлээ. Мөн Цагаанчулуут, Отгон, Шилүүстэй, Завханмандал, Дөрвөлжин, Цэцэн-Уул, Баянхайрхан, Тэс, Баянтэс, Их-Уул, Идэр, Тосонцэнгэл сумын I, II сургуулийн дотуур байранд ЯХИС-гийн санхүүжилтээр 269.980.542 төгрөгний өртөг бүхий гал тогооны ариун цэврийн хэрэглэл, усны сав, ус цэвэршүүлэгч зэргийг нийлүүлээ. Үдийн цайнд нийт 7781 хүүхэд хамрагдаж байна. Үдийн цай болон эрүүл хоол хүнсний талаар сургууль цэцэрлэгийн 63 удирдах ажилтан, Дэлхийн зөн ОУБ-н санхүүжилтээр сургуулийн эмч 28 хүн, Мерси кор, Дэлхийн зөн БСГ-ын санхүүжилтээр 63 тогоочийн сургалтыг зохион байгууллаа.	90

<p>1.2.12.Улиастай сумын Жаргалант, Чигэстэй баг, Тосонцэнгэл сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг барьж дуусган, Цагаанхайрхан, Яруу, Цагаанчулуут, Сонгино сумдын цэцэрлэгийг шинээр барих асуудлыг шийдвэрлэнэ.</p>	<p>Улиастай сумын Чигэстэй баг, Сантмаргаз суманд тус бүр 100 хүүхдийн, Отгон суманд 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг шинээр барьж ашиглалтанд орууллаа. Яруу сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга дуусах шатандаа, Цагаанхайрхан суманд 100 хүүхдийн барилга баригдах санхүүжилтийн асуудал шийдэгдээд байна.</p>	<p>70</p>
<p>1.2.13. Мэргэжлийн боловсрол олгох сургуулиудын үйл ажиллагааны үндсэн чиглэл, сургалтын хөтөлбөрийг бүс, орон нутгийн бодит хэрэгцээнд тулгуурлан зохицуулах чиглэл баримтална.</p>	<p>МУИС-ийн ЭЗсС бүс нутгийн онцлог, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн Аялал жуулчлалын менежмент, Татварын нябо хяналтын анги, МСҮТ Компьютер электроникийн засварчны ангийг шинээр нээн хичээллүүлж байна. МСҮТ-ийн салбарыг Тосонцэнгэлд нээж ойн нөхөн сэргээлт, жимс жимсгэний мэргэжлээр 60 хүүхэд суралцаж байна. Хичээлийн байрыг засварлаж, сургалтын хэрэглэгдэхүүнээр ээлж дараатай хангах арга хэмжээ авч байна.</p>	<p>70</p>
<p>1.2.14.Аймгийн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийг түшиц сургууль болгон өргөтгөж, Тосонцэнгэлд шинээр Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв байгуулж, шинэ техник технологи нэвтрүүлэн, аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарт шаардлагатай мэргэжилтэй ажилчин бэлтгэх асуудлыг шийдвэрлэнэ.</p>	<p>Аймгийн МСҮТ нь 2009 онд магадлан итгэмжлэлд хамрагдсаны зэрэгцээ цаашид, баруун бүсийн барилгын өргөн мэргэжилтэн бэлтгэх түшиц сургууль болон өргөжих юм. 2009 онд тус сургуульд АХБ-ны БХХ-ийн хүрээнд барилга, автомеханикийн иж бүрэн тоног төхөөрөмж, компьютерийн лабортори, 2 ангийн ширээ сандал нийлүүлэхээр болоод байна. Мянганы сорилтын сангаас зарласан Өрсөлдөөнт тэтгэлэгт хөтөлбөрийн шалгаруулалтанд тус сургуулийн багш нарын боловсруулсан “Төгсөгчдөд зуучлах төв” байгуулах төслийн санал дэмжигдэн нийт 42000 ам долларын санхүүжилттэй төсөл хэрэгжиж байна. Мөн Монголын Мянганы сорилтын сангийн хөтөлбөрт улсын хэмжээнд 15 МСҮТ сонгогдсон бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд манай аймгийн МСҮТ-ийн Сантехник, гагнуурын дадлагын газрыг засварлаж, тоног төхөөрөмж нийлүүлэхээр шийдвэрлэгдлээ. Тосонцэнгэл дэх МСҮТ-ийн салбарт Ойн нөхөн сэргээлт, жимс жимсгэний анги шинээр нээн 60 хүүхэд суралцаж байна. Оюу толгой төслийн санхүүжилтээр Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлын хүрээнд МСҮТ-ийг түшиглэн 80 хүнд мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах бэлтгэл хангагдаж байна.</p>	<p>70</p>
<p>1.2.15. Аймгийн Хөгжим бүжгийн коллежийн хичээлийн байрын барилгыг шинээр барьж, мэргэжлийн өндөр чадвартай багшлах боловсон хүчин, сургалтын тоног төхөөрөмжөөр бүрэн хангах замаар соёл урлагийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэжлийг дээшлүүлэх түшиц сургууль болгон бэхжүүлнэ.</p>	<p>Хөгжим бүжгийн коллежийн хичээлийн байрын өргөтгөлийн барилгыг “Эл-Би-Си” ХХК барьж байгаа бөгөөд барилгын ажлын явц хэвийн үргэлжилж байна.</p>	<p>50</p>
<p>1.2.16.МУИС-ийн харъяа Эдийн засгийн салбар сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэх, боловсон хүчнийг чадваржуулахад дэмжлэг</p>	<p>Тус сургуульд Аялал жуулчлалын менежментийн ангийн дадлагын гэр баазтай болох, зарим Мэргэжлийн тэнхмүүдэд лабортори байгуулахад нь дэмжлэг үзүүлэхээр төлөвлөөд байна.</p>	<p>10</p>

	үзүүлнэ.		
	1.2.17.Аймгийн эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт дутагдалтай байгаа хүний нөөцийг бүрдүүлэх, байгаа нөөцөө зохистой байршуулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.	Аймгийн эдийн засаг, нийгмийн салбарт дутагдалтай байгаа хүний нөөцийг бүрдүүлэх, байгаа нөөцөө зохистой байршуулах бодлого барин ажиллаж байна. Мөн эрүүл мэнд, боловсролын салбарын хүний нөөцийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж мөрдөн ажиллаж байна.	50
	1.2.18.Эдийн засгийн салбар сургуулийн дэргэдэх “Баруун бүсийн нийгэм эдийн засгийн судалгааны төв”-ийн үйл ажиллагааг дэмжиж орон нутгийн хөгжлийн бодлого тодорхойлоход шаардагдах судалгааг хийлгэж хамтран ажиллана.	2009 онд тус судалгааны төвөөр Аймгийн хүн амын амьжиргааны түвшинг тогтоох судалгааг хийлгэхээр төлөвлөсөн боловч эдийн засгийн хямралт байдлаас шалтгаалан хойшлуулсан байна.	10
<b>СОЁЛЫН БОДЛОГО</b> <b>Үндэсний уламжлалт соёл урлагийг хөгжүүлэн, өрсөлдөх чадвартай уран бүтээлийг нэмэгдүүлэн, соёл урлагийн байгууллагуудын менежментийг сайжруулан, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх нь энэ салбарын гол зорилт болно.</b>	1.2.19.Аймгийн соёл урлагийн салбарыг 2009-2012 онд хөгжүүлэх бодлогыг тодорхойлж, аймаг, сумдын Засаг даргын дэргэд “Морин хуур”-ын хамтлаг, чуулга байгуулна.	Соёл урлагийн салбарыг 2009-2012 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулан холбогдох суурь судалгааг авч нэгтгэж байна. Аймгийн Засаг даргын Морин хуурын чуулгын багшаар Алдархаан сумын соёлын төвийн эрхлэгч Ю.Дэлгэрнасан ажиллаж, сумдын морин хуурын хамтлагийн багш бэлтгэх болон, морин хуурын цөм сургалт зэрэг шаталсан сургалтуудыг зохион байгууллаа. Морин хуурын хамтлаг, чуулгын хүүхдийг морин хуур хөгжим, тоглолтын хувцастай болгох асуудлыг шийдвэрлээд байна. Аймгийн соёл урлагийн салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийнхэн судалгааг авч нэгтгэн, соёлын мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийнхэнд хүргүүлэн улсын хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулах ажил эхлээд байна. Аймгийн Засаг даргын дэргэд морин хуурын чуулга, сумдын засаг даргын дэргэдэх хамтлагуудад 25-35 морин хуурч хүүхдийг хамруулан чуулга хамтлаг байгуулагдан одоогоор 580 гаруй хүүхэд морин хуур хөгжимд суралцаж байна. Аймгийн наадмын нээлтэд 300 морин хуурч, 100 уртын дуучин, 80 бүжигчинг оролцуулсан арга хэмжээг зохион байгуулав. морин хуурын сургалтыг 3 удаа зохион байгуулан давхардсан тоогоор 70 гаруй багш сурагчдыг хамруулан сургаж 500 морин хуурыг сургууль, сумдын соёлын төвд хүлээлгэн өгөөд байна.	90
	1.2.20.Аймгийн Хөгжимт жүжгийн театрыг мэргэжлийн чадварлаг, уран бүтээлчдээр ханган бэхжүүлнэ.	Л.Ванганы нэрэмжит ХЖТ 2008 онд 46 орон тоотой ажиллаж байсан бол 2009 онд дуучин, хөгжимчин, бүжигчин, концертмейстр, найрал дууны багш , борлуулалтын менежерээр 13 хүнийг үндсэн болон гэрээт уран бүтээлчээр авч ажиллуулав. Мөн боловсон хүчнийг мэргэшүүлэх, мэргэжлийн түвшин ур чадварыг дээшлүүлэх хүрээнд 18 уран бүтээлчийг магистрын болон бакалаврын сургалтанд хамруулж, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар ахиц дэвшилттэй ажиллаж байна. Үзэгчдийн танхимын шал, сандлын засварыг дуусгаж, задгай талбайн зориулалт бүхий орчин үеийн өндөр хүчин чадалтай 30 сая төгрөгийн өртөг бүхий дууны тоног төхөөрөмжтэй болголоо.	50

		<p>2010 онд ХЖТеатрт ажиллаж байгаа уран бүтээлчдийг мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр хангахад онцгой анхааран СУИС, Завханы ХБК, Сити дээд сургууль төгссөн 15 уран бүтээлчийг авч ажиллуулж байна. Мөн СУИС-ийн магистрийн сургалтанд 2 жүжигчин, бакалаврын сургалтанд 1 жүжигчин, ХКБ-ийн бакалаврын сургалтанд 3 жүжигчин, Соёлын коллеж дээр мэргэжил дээшлүүлэх сургалтанд 2 бүжигчин, 2 хөгжимчинг хамруулан мэргэжлийг нь дээшлүүлэв. УДЭТ-ын гэрлийн инженер Эрдэнэбатыг урин өөрийн байранд мэргэжлийн дадлага сургуулилт хийж гэрлийн техникч, дууны техникч, тайзны техникдын мэргэжлийг дээшлүүлэн нийт 19 цагийн анхан шатны сургалт зохион байгуулав. Одоо театрт магистр 3, бакалавр 30 дипломын дээд 14, мэргэжилтэй ажилтан 4 нийтдээ ажилчид, уран бүтээлчдийн 82% мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдаад байна.</p>	
	<p>1.2.21.Аймгийн Музейг “Аялал жуулчлал- сургалт танин мэдэхүйн төв” болгон өргөжүүлж, цахим техник хэрэгслээр ханган, сан хөмрөгийг баяжуулан, зарим ховор үнэт үзмэрийг гадаад орнуудад аялуулан сурталчлах ажлыг зохион байгуулна.</p>	<p>Аймгийн Музейг Сургалт танин мэдэхүйн орчин болгох ажлын хүрээнд 2009 онд цэцэрлэг, ЕБС-ийн сурагчдын мэдлэгийг гүнзгийрүүлж, орон нутгаа судалж мэдүүлэх зорилгоор танхимаас гадуурхи сургалтыг “Улиастай хот”, “Б.Явуухулангийн намтар уран бүтээл”, “Хүн бай байгаль”, Монголын угсаатан судлал” зэрэг сэдвээр зохион байгуулж, Улиастай сумын 5 сургууль, 3 цэцэрлэгийн 600 хүүхэд, 15 багш хамрагдсан байна. БСШУЯ-наас орон даяар зохион байгуулсан Музей үзэх сарын аянд ЧЭЦС, ЖЦС-ын 1800 сурагч, 20 багш хамрагджээ. Аймгийн музейд 2009 онд ОУОХ-ны Хүндэт гишүүн Ш.Магваны танхим, Хурандаа комиссар Д.Загдгочоогийн буланг шинээр байгуулж, 94 төрлийн 431.0 мянган төгрөгийн үнэ бүхий үзмэрийн баяжилт хийгдсэн байна. 2010 онд Музейг мэдээлэл сургалт, сурталчилгаа, эрдэм шинжилгээний төв байгууллага болгох чиглэлийн хүрээнд сургалтын хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан ЕБС-ийн сурагчид, МСҮТ, ХБК-ийн оюутан сурагчдын дунд онол практик, танин мэдэхүйн хичээл, сургалт сурталчилгааны ажлуудыг зохион байгуулан МСҮТ, ХБК-ийн оюутнуудын бүтээлээр үзэсгэлэн, уралдаан тэмцээн зохион байгуулав. МУ-ын УГЗ нэрт найруулагч Л.Ванганы 90 насны ойн хүрээнд ЕБСургуулиудын ахлах ангийн сурагчид, МСҮТ, ХБК-ийн сурагчдын дунд “Завхан нутаг сайхан нутаг” гар зургийн уралдаан зарлан 80 гаруй хүүхэд хамрагдан оролцож эхний 5 байрыг шалгаруулав. Улиастай сумын Жавхлант толгой дахь хутагтуудын гүдэн цогцолборыг холбогдох байгууллагатай хамтран шинэчлэн засварлав. МУ-ын баатар, Армийн генерал Б.Доржийн алдрын танхимыг шинээр байгуулан, Л.Ванганы танхимыг шинэчлэн дэглэлт хийлээ. Байгууллагын тохижилт үйлчилгээ, хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд шинээр сүүлийн үеийн дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмж суурилуулав. Шинээр чонын чихмэл, Үлэмжийн чанар дууны эх хувь, Байгалийн зураг, оньсон тоглоомууд 30 гаруй нэр төрлийн 100 гаруй тоглоом зэргээр үзмэрт баяжуулалт хийгдлээ.</p>	90
	<p>1.2.22.Аймгийн төв номын санд Lib4U программ нэвтрүүлэн дотоодын сүлжээнд холбож, шинжлэх ухаан технологийн дэвшлийг номын сангийн уламжлалт үйлчилгээтэй хослуулан дэвшилтэт шинэлэг үйлчилгээг нэвтрүүлнэ.</p>	<p>Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж номын сангийн үйл ажиллагааг автоматжуулах, номын санд орчин үеийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор 8 компьютер дотоод сүлжээнд холбогдон LIB4U программыг авч 8417ш номыг программд оруулж электрон каталогитой боллоо. Уншлагын танхимд уншигчдад зориулсан компьютерийг байрлуулж интернэтээс болон төрөл бүрийн CD-ны тусламжтайгаар 73 уншигчидад электрон хэлбэрээр мэдээлэл өглөө. Завхан аймгийн Б.Явуухулангийн нэрэмжит Төв номын сан нэртэй BLOG хийж интернэтэд байрлуулж мэдээллийг тухай бүр нь шинэчилж байна. <a href="http://www.zalibrary.gblog.mn">www.zalibrary.gblog.mn</a> 2010 онд Аймгийн төв номын сангийн тоног төхөөрөмжийг дотоод сүлжээнд холбуулан 1156 номыг электрон каталогид оруулав. Дэлхийн зөн олон улсын байгууллагын Завхан хангай ОНХХ-тэй хамтран аймгийн төвийн ЕБС-ийн 1-5-р ангийн сурагчдын дунд “Миний эх орон бидний ирээдүй” сэдэвт гар зургийн уралдаан, 7-р ангийн сурагчдын дунд “Цэвэр ус-эрүүл амьдрал сэдэвт зохион бичлэгийн уралдаан, 8-р ангийн сурагчдын дунд”Монгол бичгээр хэн цэвэр сайхан бичих вэ” зэрэг уралдаан тэмцээн зохион</p>	90

		байгуулав. Мөн ЕБС-ийн 9-11 ангийн сурагчдын дунд “Ухаан далай номоос эхтэй”сэдэвт Дэвжээ тэмцээн зохион байгуулав.Нийтийн уншлагын танхимд уншигчдад зориулсан компьютерийг ашиглан интернет болон CD-ны тусламжтайгаар 68 уншигчдад электрон хэлбэрээр мэдээлэл өглөө.Л.Ванганы 80 насны ойг тохиолдуулан нийт 8-р ангийн сурагчдын дунд Л.Ванганы “Эрхий Мажиг” зохиолоор уншигчдын бага хурал зохион байгуулав. Одоогоор 4325 уншигч 25815 ирэгсдэд 81032 ном олгож үйлчлэв.	
	1.2.23.Сумын соёлын төвүүдийн барилгын 30 хувьд засвар хийж, хөгжмийн зэмсэг, техник хэрэгслээр хангахын зэрэгцээ Эрдэнэхайрхан, Цэцэн-Уул, Асгат, Баянтэс, Тэлмэн сумдын соёлын төвийн барилгын зураг төсвийг хийлгэж шинээр бариулах асуудлыг эхний ээлжинд шийдвэрлэнэ.	2010 онд Тэлмэн сумын соёлын төвийн барилгын суурь тавигдан, Цэцэн-Уул сумын соёлын төвийн барилгын асуудал шийдэгдэх боломжтой боллоо. Ургамал Отгон, Цэцэн-Уул суманд хөгжим техник хэрэгсэл, Алдархаан, Шилүүстэй суманд техник хэрэгсэл олгож нийтдээ 12.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.	70
	1.2.24.Бүх сумдыг Орон нутгийг судлах танхимтай болгож, сан хөмрөгийг нь баяжуулна.	2009 онд Орон нутаг судлах танхимгүй 8 сумыг танхимтай болгосноор бүх сумд орон нутаг судлах танхимтай боллоо. Музей техникийн ажилтны ажлыг аттестатчлан, сургалт зохион байгуулж,мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, гарын авлагаар хангалаа. Шинээр 339 төрлийн 1,836,000 төгрөгийн үнэ бүхий үзмэрээр баяжууллаа. Түдэвтэй сумын ОНС танхимд Монгол Улсын урлагийн гавъяат зүтгэлтэн Л.Ванганы алдрын буланг шинээр байгуулаад байна.	100
	1.2.25.Сумдын номын сангуудыг дэлхийн болон Монголын сонгодог зохиолуудаар баяжуулан, жил бүр шинэ номын сэлбэлт хийж хөдөөгийн малчдад номын сангийн үйлчилгээг ойртуулна.	2010 оны шилдэг ном болох 15 нэр төрлийн 330 ширхэг буюу 1764.0 мян төгрөгийн номыг сумдын номын санд хувиарлан хүргүүлэв. Ургамал, Отгон, Их-Уул, Нөмрөг, Сонгино зэрэг сумдад тус бүр 5 ширээ 10 сандал нийлүүлэн үнийн дүнгээр 2337.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Сумдын номын сангууд нь нүүдлийн номын санг байнга ажиллуулан үр дүнд хүрээд байна.	90
<b>ДҮН</b>			<b>71,6</b>
<b>1.3. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХҮН АМ ЗҮЙН БОДЛОГО</b> <b>Иргэддээ чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, өнөөгийн болон ирээдүйн сайн сайхны төлөө төрөөс үзүүлж буй халамж, даатгалын үйлчилгээг иргэн бүрт хүргэж, тэдний эрх ашгийг хамгаалж ажиллах нь энэ салбарын гол зорилт болно.</b>	1.3.1.Сумдын нийгмийн даатгалын байцаагчдын ажиллах нөхцлийг сайжруулан, компьютер техник хэрэгслээр хангаж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болгон нийгмийн даатгалын үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ.	Тэлмэн, Эрдэнэхайрхан, Цэцэн-Уул сумдын байцаагч нарыг компьютероор хангаж, мөн хэлтсийн мэргэжилтнүүдийн ажлын нөхцлийг сайжруулах зорилгоор компьютер техник хэрэгслээр хангахад зориулж нийтдээ 5146.1 мянган төгрөг зарцуулсан. Мөн Нийгмийн даатгалын хэлтсийн гаднах орчны тохижуулалтанд 20 ширхэг шар хуайс шинээр тарьж, 2 цэцгийн мандал хийж, конторын гаднах хайс, сандлаа шинэчилсэн бөгөөд иргэдэд үйлчлэх сурталчилгааны ширээ сандал байрлуулсан. Шилэн кабелийн байнгын холболтоор холбогдож ажил үйлчилгээг шуурхай гүйцэтгэх боломжоор хангагдан ажиллаж байна. Аймгийн эдийн зааг нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу “төрийн үйлчилгээг багт” хүргэх ажлын бүрэлдэхүүнд хэлтсийн байцаагч нар оролцож 24 сумын 88 хөдөөгийн багаар явж нийгмийн даатгалын багц хуулийг сурталчилах, иргэдийн санал хүсэлтийг сонсон асуудлыг газар дээр нь шийдвэрлэх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, малчдыг даатгалд хамруулах ажил зохион байгуулж ажилласан.	90
	1.3.2.Малчдыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд бүрэн хамруулна.	2009 эхний 10 сарын байдлаар Эрүүл мэндийн даатгалд шинээр оюутан сургагч 232, малчин 424 бизнес эрхлэгч 188 хүнээр хамрагдалтыг нэмэгдүүлж, нийт оюутан сурагч 1746, малчин бизнес эрхлэгч 5664 ЭМД-д хамруулснаар 50.9 сая төгрөгийн орлого орууллаа. 2010	90

		оны 10 сарын 10-ны байдлаар ЭМД-д шинээр оюутан сурагч 98, малчин, ажилгүй иргэн 299, хүнээр хамрагдалтыг нэмэгдүүлж нийт 8152 даатгуулагчаас 59042,6 төгрөгний орлого оруулсан. Нийгмийн даатгалын сайн дарын даатгалд 1680 хүн хамрагдаж 141300,0 мянган төгрөгийн орлого оруулсан. Эрүүл мэндийн даатгалын хуулийн өөрчлөлтөөр сургалт сурталчилгааны ажлыг эрчимтэй зохион байгуулж байна.	
	1.3.3.Стратегийн болон томоохон орд газруудаас олсон орлогоос иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх талаар Засгийн газраас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлнэ.	Иргэн бүрт олгох 70000 мянган төгрөгийг 2 үе шаттайгаар шуурхай зохион байгуулж ажиллаа. Аймгийн нийт 74906 хүн амын 96,1 хувь буюу 72000 хүн д 5250,0 сая төгрөгийг олгоод байна. Иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлсэн иргэнд олгогдож буй сар бүрийн 10000 төгрөгийг 24000 хүнд 8,9,10 сарын 720,0 сая төгрөг санхүүжүүлж олгож байна.	50
	1.3.4.Шинээр гэр бүл бологсад, нийт болон шинэ төрсөн хүүхдэд мөнгөн тусламж, тэтгэмжийг үргэлжлүүлэн олгоно.	Шинээр гэр бүл болсон 383 хосод 191500.0 мянган төгрөг, Шинээр төрсөн 1355 хүүхдэд 135500.0 мянган төгрөг, Хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 28917 хүүхдэд 791648.6 мянган төгрөгийг тус тус олгоод байна. Хуулиар зогсоогдсон.	70
	1.3.5.Шинээр 3 дахь хүүхдээ төрүүлсэн гэр бүлд 300.0 мянган төгрөг, “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонтой эхэд 500.0 мянган төгрөг, нэгдүгээр зэргийн одонтой эхэд 1.0 сая төгрөгийн тэтгэмж олгоно.	Алдарт эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд 4322 хүнийг хамруулж 275000.0 мянган төгрөгийг олгов. 2010 онд Му-ын Ерөнхийлөгчийн зарлигаар аймгийн хэмжээнд алдар эхийн нэгдүгээр одонгоор 6, хоёрдугаар одонгоор 49 эх шагнагдсан байна. 2010 онд алдарт эхийн мөнгөн тэтгэмжинд 4382 хүнд 286,1 сая төгрөг зарцуулаад байна. 4 хүүхэд төрүүлж өсгөж байгаа эх 2-р одонгоор, 6 хүүхэд төрүүлж өсгөж байгаа эх 1-р одонгоор шагнагдахаар хууль батлагдан гарсан.	30
	1.3.6.Өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачлагыг дэмжих “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж ажиллана.	10 сарын 30-ны байдлаар аймгийн хэмжээнд 200 өрхийг хөгжлийн төлөвлөгөөтэй болгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, жижиг зээл, мэргэжил олгох сургалтанд хамруулж, ХЭДСангаас 72968.7 мянган төгрөгийг зарцуулаад байна.2010 онд 376 өрхийг өрхийн хөгжлийн төлөвлөгөөтэй болгох зорилт тавин судалгааг гаргаж. ХЭД 5 төрлийн ажил үйлчилгээнд 177 өрхийн 244 хүн хамрагдаж 55,7 сая төгрөг, бусад тусламж үйлчилгээнд 197 өрхийн 719 хүнд 24,8 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж үзүүлсэн.	70
	1.3.7.Өрхийн нэг иргэнийг ажилтай болгох замаар өрхийн дундаж орлогыг 1.0 сая төгрөгт хүргэнэ.	Энэхүү хөтөлбөрт 20 өрхийг хамруулж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулж 40000.0 мянган төгрөгийг зарцуулсан. 376 өрхийн 1791 иргэнийг ХЭД, нийгмийн халамжийн үйлчилгээнд тус тус хамруулж, 2010 оны 10 сарын байдлаар 18 өрхийн 18 иргэнийг тогтмол ажлын байранд зуучилсан.	50
<b>Гэр бүл бат бэх байх, үр хүүхэд аюулгүй орчинд хөгжих боломжийг бүрдүүлж тэдний үүсгэл санаачлагын байгууллагыг дэмжиж, монгол ёс заншил өв уламжлалаа хүндэтгэн сэргээж хөгжүүлэх, байгаль дэлхийгээ</b>	1.3.8.Аймгийн Хүүхэд Залуучуудын ордны үйл ажиллагааг өргөтгөж, хүүхэд залуучууд, гэр бүлийн нийгэм, соёлын цогцолбор төв болгоно.	Аймгийн Засаг даргын 2009.10.13-ны 215 дугаар захирамжаар ХТХ-ийн үйл ажиллагааг өргөтгөж, ХЗО-ны үйл ажиллагааг хариуцсан дэд захирлын орон тоог бий болгож, Морин хуур, хөгжим, уртын дуу, англи, япон, хятад, солонгос, орос хэлний, шатар, даам, компьютер, зураг дизайны 16 дугуйлан хичээллэж, дугуйлангийн эрдмийн баярт нийт 60 гаруй хүүхэд багачууд оролцож 300 гаруй үе тэнгийн хүүхэд багачууддаа сурсан мэдсэнээ харууллаа. 2010-2011 Оны хичээлийн жилд 7 төрлийн дугуйланд 200 хүүхэд хичээллүүлж байна.	90
	1.3.9.Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг өргөтгөж, хүүхэд залуучуудын амралтын төв болгож менежментийг өөрчлөн,	Хүүхдийн Даян-Очир зуслангийн худгийн засвар, гал зуухны засвар, байрны засваруудыг хийхэд 3865.0 мянган төгрөгийг зарцуулсан. Мөн зусланг 7 ээлж ажиллуулж, 1223 амрагчдыг ая тухтай амрааж хүүхдүүдийн амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлсэн байна.Халамжийн сувилалын ээлжинд 236 хүүхдийг 5-13 хоног амрааж 9540.0 мянган	90

хайрлах зөв чиглэл хандлагатай эх оронч иргэн төлөвшүүлэх нь хүүхэд, залуучуудын талаар тавих бодлогын гол зорилт болно.	орчин нөхцлийг сайжруулна.	төгрөгийг зарцуулсан байна. Хүүхдийн Даян-Очир зуслан 2010.06.10-2010.08.20 хүртэл 6 ээлж ажиллахаар үйл ажиллагаагаа явуулж 350 гаруй хүүхдийг ая тухтай амруулахын зэрэгцээ аймаг, бүсийн сургалт, семинар, зөвлөгөөн 9 удаагийн арга хэмжээг 2-5 хоногоор өндөр түвшинд зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн үүнд 1000 гаруй хүмүүс хамрагдан амт чанар сайтай хоол, ундаар үйлчилэн үйлчлүүлэгчдээс өнөдр үнэлтийг авсан байна. Мөн бассейн, саун, халуун усыг өөрийн хөрөнгөөр засаж, тохижуулан ажилд оруулж нийтдээ 5 сая гаруй төгрөгийг зарцууллаа	
	1.3.10.Хүүхдийн эрхийг хамгаалах хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлнэ.	Аймгийн хэмжээнд хүүхдийн эрх зүй, нийгмийн хамгааллын хөдөлмөрийн асуудлаар мониторинг хийгдэх ажлын удирдамжийг боловсруулж, сумдад хүргүүлсэн. Сумдаас 9-н төрлийн судалгааг авч нэгтгэх ажлыг хийсэн. Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр “нэг хүүхэд нэг байгууллага”, “хүүхдийн нэг өдөр” зэрэг арга хэмжээг зохион байгуулж эхний хагас жилийн байдлаар 226 хүүхдийг хамруулан олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр шинэ хувцас уут дүүрэн билэгтэй баярлалаа. Мөн аймгийн засаг дарга хүүхдийн баярыг угтаж аймгийн бүтэн өнчин 104 хүүхдийн хадгаламжийн дансанд дахин тус бүр 70000 төгрөгийг байршуулан 18 нас хүрсэн 9 хүүхдийг аймгийн баяр наадамд урилгаар оролцуулсан нь хүүхдүүдийн сэтгэлд хүрсэн үйл ажиллагаа болсон.	90
	1.3.11.Хүүхэд өсвөр үеийнхний өөртөө зориулсан ажил үйлчилгээг дэмжих төсөл хэрэгжүүлж, хүүхдийг өөрийн удирдлагын байгууллагаар дамжуулан хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.	Мөн НҮБ-ын хүүхдийн сан, Хүүхдийн төлөө газрын төслөөр хүүхдийн оролцооны байгууллагыг чадавхижуулах сургалтыг аймагт хүүхдийн оролцооны байгууллагын төлөөлөгч хүүхдүүдийн дунд зохион байгуулав. Сургалтанд 17 хүүхэд хамрагдсан. Английн Хүүхдийг Ивээх сан, Хүүхдийн төлөө газартай хамтран “Хүүхдийн эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалтыг насанд хүрэгчдийн дунд явуулж, 20 хүн хамрагдлаа. Завхан Говь-Алтай аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүдийн зөвлөгөөний материалаар “Хүүхдийн оролцооны байгууллагыг хөгжүүлэхэд, олон нийтийн үүргийг нэмэгдүүлэх нь” номыг гаргасан.”Завхан нутгийн хүүхдүүд” сонины, улирал бүр тогтмол гаргаж байна. 24 сумдад Хүүхдийн чуулганг газар дээр нь зохион байгуулж аймгийн нэгдсэн чуулганыхаа төлөөлөгчдийг сонгож, чуулганыхаа шийдвэрийг сумдын шийдвэр гаргах түвшний хүмүүст танилцуулж чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг ойрын болон хэтийн хугацаагаар төлөвлөн гаргаж ажиллаж байна. Баруун бүсийн хүүхдийн чуулганд аймгийн Хүүхдийн нэгдсэн зөвлөл төлөөлөгчид ДЗОУБ-ын санхүүжилт дэмжлэгтэйгээр амжилттай оролцсон. 12 сарын 10 нд аймгийн хүүхдийн нэгдсэн 27-р чуулганыг зохион байгуулж явууллаа.	90
	1.3.12.Хүүхдийн байгууллагын олон талт үйл ажиллагааны эдийн засгийн эх үүсвэрийг дэмжих зорилгоор “Хүүхдийн төлөө сан” бий болгоно.	Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн дэргэд “Хүүхдийн төлөө сан” нээж, 2.5 сая төгрөг, 24 сумдад хүүхдийн төлөө зөвлөл байгуулагдан 3000.0 мянган төгрөгийн сантай болоод байна. хүүхэд хамгааллын чадавхийг бэхжүүлж, сумдын Засаг дарга нарын хүүхэд хамгааллын тухай ойлголт мэдээллийг нэмэгдүүлэх сум орон нутагт хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг чанаржуулах хөдөөгийн анхан шатанд хүрч ажиллах сумын хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх удирдлага арга зүйгээр хангах зорилт тавин ажиллаж байна. 2010 оны эхний хагас жилд нийт Отгон, Шүлүүстэй, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Алдархаан, Эрдэнэхайрхан, Ургамал, Завханмандал, Дөрвөлжин, Идэр, Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул зэрэг 13 суманд ажиллаж үйл ажиллагаатай нь газар дээр нь танилцаж арга зүйн зөвлөгөө өгч сумын хүүхдийн төлөө зөвлөл, Засаг даргын тамгын газрын ажилтнуудадтай уулзаж хүүхдийн талаар төрөөс баримтаж буй бодлого үйл ажиллагаа, хүүхэд хамгаалал, хүүхдийн оролцооны талаарх ойлголт мэдээлэл өгч Засаг даргын өдөр тутамын үйл ажиллагааг хангаж байдаг багийг чадавхижуулах ажлыг орон	70

		нутагт нь зохион байгуулан ажиллаа. Төрийн тусгай сангийн хуулийн дагуу Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлд төсөл бичсэн. Орон нутагт хүүхдийн төлөө санг аривжуулах, хүнд нөхцөл дэхь хүүхэд хамгааллыг сайжруулах чиглэлээр аймгийн Засаг даргын 2010 оны 40 тоот захирамжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	
<b>Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулж, ахмад наснаас суралцах тэдэнд туслах, үүсгэл санаачлагыг дэмжиж хамтран ажиллах нь тэдний төлөө явуулах бодлогын гол зорилт болно.</b>	1.3.13.Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, иргэдийг чадваржуулах бодлого баримталж ажиллана.	2009 онд халамжийн үйлчилгээний менежер программыг шинээр нэвтрүүлэх болсонтой холбогдуулан сумдын мэргэжилтнүүдийн сургалтыг зохион байгуулсан. 24 сумын мэргэжилтнүүдийг notebook, принтерээр бүрэн хангаж 27 сая төгрөг, ажиллах таатай нөхцлийг бий болгох зорилгоор ширээ сандал, сейфээр хангах ажлыг хэрэгжүүлж 11 сая төгрөгийг зарцуулаад байна. Мөн иргэдийг чадваржуулах, айл өрхийг ядуурлаас гаргах зорилгоор Улиастай сум 100 өрх, Тосонцэнгэл 60 өрх, Их-Уул 40 өрх, бусад сумууд тус бүр 10 нэн ядуу өрхүүдийг сонгон авч нийгмийн халамжийн бүхий л үйлчилгээнд хамруулж байна. 2010 онд 376 өрхийг ядуурлаас гаргах зорилт тавин ажиллаж, нийт өрхийн 61 хувьд өөрчлөлт гарсан байна. 4 суманд 3 үйлдэлтэй принтер, 20 суманд скайнер өгсөн. Бар код уншигчийг 24 суманд хүргэх бэлтгэл ажлыг хангаад байна.	70
	1.3.14.Ахмад настануудын эрүүл мэндийг нөхөн сэргээх, нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор Улаан хаалга Хожуулын голын амралтыг ахмадын амралт болгон өргөжүүлж, Баянзүрх, Зартын амралтын үйл ажиллагааг дэмжинэ.	Мөн Улаан хаалга дахь ахмадын рашаан сувилал, Улиастай сумын ахмадын өдрийн сувилалын тохижилт үйлчилгээг сайжруулах зорилгоор нийтдээ 3.0 сая төгрөгийн засвар үйлчилгээг хийсэн бөгөөд Рашаан сувилалд 150 ахмад настан болон ХБИ, өдрийн сувилалд 50 ахмад настныг амраан хөнгөлөлтөнд 12.6 сая төгрөг зарцуулсан. Тосонцэнгэл сумын Хожуулын рашаан амралтанд тойргийн сумдын 50 ахмад настныг амрааж 4.5 сая төгрөг зарцуулсан. 2010 онд ОНОТХУ-г ХБИ, ахмад настанд үзүүлэх үйлчилгээг тендер зарлан зохион байгуулж 8 байгууллагыг шалгаруулан 20,1 сая төгрөгийн үйлчилгээг 1295 хүнд үзүүлсэн. Улиастай сумын өдрийн сувилалд 2010 оны 10 сараас 2-р ээлж ажиллаж 6 сумын 35 хүн, улаан хаалгын амралтанд 5418,1 төгрөгийг зарцуулсан.	70
	1.3.15.Ахмад настанд гэрэл цахилгааны үнийн хөнгөлөлт, аймгийн төвийн ахмадуудад унааны хөнгөлөлтийг хуулийн дагуу үзүүлнэ.	Улиастай сумын өндөр настан ХБИ 110 хүнд цахилгаан гэрлийн үнийн хөнгөлөлт үзүүлж Улиастай эрчим ХХК-д 3200.0 төгрөг, Тосонцэнгэл суманд 1200.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн. 2010 онд Улиастай Тосонцэнгэл сумын ахмад настан ХБИ-д цахилгаан гэрлийн үнийн хөнгөлөлтөнд 8,0 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж сумдад нь шилүүлээд байна.	90
	1.3.16.Ахмадын өдрийн сувилалыг зориулалтын тоног төхөөрөмжөөр хангаж, ахуй хангамжийг нэмэгдүүлэн, үйл ажиллагааг өргөжүүлнэ.	Улиастай сумын ахмадын өдрийн сувилалын тохижилт үйлчилгээг сайжруулах зорилгоор нийтдээ 3.0 сая төгрөгийн засвар үйлчилгээг хийсэн бөгөөд өдрийн сувилалд 50 ахмад настныг амраан хөнгөлөлтөнд 12.6 сая төгрөг зарцуулсан. Энэ онд Улиастай сумын ахмадын өдрийн сувилалд 500,0 мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийж 12 сумын 80 ахмадыг амрааж 2300,0 мянган төгрөгийг зарцуулаад байна. Мөн өдрийн сувилалын тохижилт үйлчилгээг сайжруулах зорилгоор барилга, тоног төхөөрөмжийн төслийг хийж ХХҮГазарт хүргүүлээд байна.	70
	1.3.17.Аймгийн ахмадын хорооны байрыг ахмадуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх төв болгон тохижуулна.	Аймгийн ахмадын байгууллагын дэргэд ахмадын хөгжлийн танхимыг байгуулан 750.0 мянган төгрөгийг зарцуулаад байна. Хөгжлийн танхимаар тогтмол 55 ахмад настан үйлчлүүлж байна. Аймгийн ахмадын хороо 6-р бага хурлаа угтаж хорооны байраа зсварлаж, аймгийн Засаг дарга байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж 500,0 төгрөгийг олгосон.	70
1.3.18.Ахмадын эрүүл мэндийн кабинет байгуулж ахмадуудад	Хүлээгдэж байгаа	00	

	үйлчлэхийн зэрэгцээ ахмад настнуудад орон сууцны нөхцлөө сайжруулах, гэр олгох, орон сууц барихад нь хөнгөлөлттэй зээл олгоно.		
	1.3.19.Ахмад настнуудын хөдөлмөрөө хоршин ажиллах санаачлагыг дэмжинэ.	Ахмад настнуудын хөдөлмөрөө хоршин ажиллах санаачлагыг дэмжин 15 ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 4.7 сая төгрөгийг зарцуулсан.	70
	1.3.20.Байгалийн гамшиг гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон иргэдэд орон гэртэй болоход нь дэмжлэг үзүүлнэ.	Байгалын гамшиг гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон 48 иргэнд орон гэртэй болоход нь дэмжлэг үзүүлж, 24 сая төгрөг зарцууллаа. 2010 оны эхний хагас жилийн байдлаар байгалийн гамшигт өртөж орон гэргүй болсон 8 иргэнд 4,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Мөн 18 нас хүрэхээсээ өмнө бүтэн өнчин болсон 24 хүртлэх насны 22 иргэнд хуулийн дагуу нийт 11,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.	70
<b>Иргэдийн ажиллах нөхцөл боломжийг хангаж ажил эрхлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хэрэгцээт мэргэжил эзэмшүүлэх нь энэ салбарын гол зорилт болно.</b>	1.3.21.Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг 2008 оны түвшнээс 3 дахин өсгөх бодлогыг хэрэгжүүлнэ.	МУ-ын засгийн газраас төрийн албан хаагчдын цалин тэтгэврийг 2010 оны 10 сараас 30 хүртэл хувиар нэмэгдүүлэхээр шийдвэр гаргасан. 2010 оны 10 сарын 1-нээс төрийн албан хаагчдийн цалин, тэтгэвэр тэтгэмжийг 30 хувиар нэмэгдүүлэн олгоод байна.	70
	1.3.22.35-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	2009 оны 10 сарын байдлаар байнгын ажлын байртай болсон 1028 хүнээс 386 хүн нь 35-аас дээш насны иргэн байна. Мөн 45-аас дээш насны иргэдийг ажилд ажилд авсан 8 албан байгууллагад ажил олгогчийг дэмжих арга хэмжээний урамшуулал 5457.3 мянган төгрөгийг олгосон. 2010 онд байнгын ажлын байртай болсон иргэдийн 360 нь 35 аас дээш насны иргэд байгаа бөгөөд 45 дээш насны иргэнийг ажилд авсан 16 байгууллагад нийт 30 хүнд 15,8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	70
	1.3.23.4000-аас доошгүй иргэдийг байнгын ажлын байртай болгож ажилгүйдлийн түвшинг эдийн засгийн идэвхитэй хүн амын 4.0 хувиас хэтрүүлэхгүй байлгана.	Ажил идэвхитэй хайж байгаа болон сургалтанд хамрагдах сонирхолтой нийт 6100 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөний зэрэгцээ 3404 иргэнийг шинээр бүртгэн интернетэд байршуулаад байна. 2105 хүнийг байнгын ажлын байртай болгож ажилгүйдлийн түвшинг эдийн засгийн идэвхитэй хүн амын тодорхой 4.0 хувиас хэтрүүлэхгүй байлгах бодлогыг баримтлан ажиллаж байна.	70
	1.3.24.2000-аас доошгүй хүнийг үйлдвэр дээрхи сургалт, Бизнес инкубатор, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, бүсийн сургалтын төвүүдээр мэргэжил олгох болон мэргэшүүлэх сургалтад хамруулж ажлын байрыг нэмэгдүүлнэ.	Мэргэжлийн сургалтанд 612 хүн, аж ахуй эрхлэх сургалтанд 225 хүн, хамрагдаж 64.2 сая төгрөг зарцуулсан. Мөн Тосонцэнгэл сумын зам барилгын "А33А" компани дээр үйлдвэр дээрх сургалтанд 20, Зоост өргөө ХХК дээр барилгын засал чимэглэл мэргэжлээр 20 хүн хамруулж 5.0 сая төгрөг зарцуулаад байна. Сургалтанд хамрагдсан нийт хүмүүсийн 219 нь байнгын ажлын байртай болсон. 2010 оны 3-р улирлын байдлаар мэргэжлийн 23 төрлийн сургалтанд 530 хүн, хамрагдаж 51,0 сая төгрөг зарцуулсан. Нийт сургалтанд хамрагдсан хүмүүсээс 200 хүн байнгын ажлын байртай болсон. Үйлдвэр дээрх сургалтанд Бэрсүм, А33А, Зоост өргөө ХХК дээр нийт 55 хүн сургалаа.	50
	1.3.25.Гадаадад ажиллах иргэдийг дэмжиж, бүртгэлд хамруулахын зэрэгцээ гадаадад ажиллаж мэргэжил эзэмшсэн	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамнаас Солонгос улсад ажиллах хүч гаргах зорилгоор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс дээр 100 иргэнийг бүртгэж хэлний шалгалтанд орох эрх олгосон.	50

	иргэдийг орон нутагтаа үйлдвэрлэл эрхлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.		
	1.3.26.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг хангаж, нийгмийн эмзэг бүлгийн болон ахимаг насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого баримталж ажиллана.	21 суманд 23 төрлийн нийтийг хамарсан ажил зохион байгуулж 755 нийгмийн эмзэг бүлгийн мргэдийг хамруулж 113.8 саям төгрөг зарцуулсан. Мөн байнгын ажлын байртай болсон иргэдийн 37 хувь нь 35 аас дээш насны иргэд байна. 2010 онд байнгын ажлын байртай болсон иргэдийн 30 гаруй хувь 35 аас дээш насны иргэд, 5 хүн нь 45 аас дээш насны иргэд тус тус байна. Мөн нийтийг хамарсан ажил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг үйл ажиллагаанд 40-өөс доошгүй хувь нь 35 аас насны иргэдийг хамруулах бодлого баримтлан ажиллаж байна.	70
	1.3.27.Орон нутгийн нөөц боломжид тулгуурлан ажлын байрны стандартад нийцсэн жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төслийн хүрээнд шинээр 25 үйлдвэр байгуулж, 648 ажлын байр бий болгохоор зорилт тавин ажиллаж байна. ЖДҮ эрхлэх иргэдэд зээлийг олгоод байна.	50
	1.3.28.Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой иргэд, аж ахуйн нэгжид зээл олгож үйл ажиллагааг нь дэмжинэ.	2009 онд ХЭД-х сангаас 140 иргэнд 70.0 сая төгрөгний зээл олголоо. Мөн ЖДҮДСангийн хөрөнгөөр хөнгөлөлттэй зээлд аж ахуй жижиг дунд үйлдвэр эрхлэгч 81 иргэнд 780.0 сая төгрөгний зээл олголоо. 2010 онд ХЭДСангаас 420 иргэнд 699,7 сая төгрөгийн жижиг зээл, 10 хүнд 1 сая хүртлэх лизингийн зээл 10,0 сая төгрөг олгоод байна.	70

**ДҮН**

**67,5**

**ХОЁР. ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ГАДААД ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ЗАМААР БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭГ ӨРГӨТГӨХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

Аймгийн эдийн засгийн онцлогт тохирсон хөгжлийн боломжит болон тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хөдөө аж ахуй, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж, тээвэр, холбоо, нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээг сайжруулан, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүний нэр төрөл тоо хэмжээг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн хурдацтай өсөлтийг бий болгоно.

<b>2.1.ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО Орон нутгийн нөөц боломжид түшиглэсэн олзворлох болон боловсруулах аж үйлдвэрийн тэргүүлэх салбарыг хөгжүүлэх, техник, технологийг шинэчлэх нь үйлдвэрлэлийн салбарын зорилт болно.</b>	2.1.1. Ашигт малтмалын эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлж, нүүрсний орд байгаа эсэхийг тогтоож бусад эрдэс баялгийг олзворлох нөхцөлийг бүрдүүлнэ.	Аймагт ашигт малтмалын хайгуулын 104 лиценз, ашиглалтын 3 лицензтэй аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна. Нүүрсний хайгуул судалгаа хийх талаар Ашигт малтмалын хэрэг эрхлэх газарт санал хүргүүлсэн болно.	30
	2.1.2. Улиастай хотод Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж хөгжүүлнэ.	Аймагт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв болон Мастер төлөвлөгөө боловсрогдож, байгаль орчны үнэлгээ хийгдэн аймгийн төвийн Өлзийт багийн нутагт 16,2 га газарт парк байгуулагдахаар бэлтгэл ажлууд хийгдсэн. 2011-2013 онд Ноос ноолуур, арьс ширний гүн боловсруулалтын үйлдвэрлэл технологийн парк байгуулах, технологийн хаягдал ус цэвэрлэх байгууламж барих талаар ХХААХҮ-ий сайдын багцад хөрөнгийн асуудал тусгагдаад байна.	50
	2.1.3. Аймгийн тэргүүлэх ач холбогдол бүхий үйлдвэрүүдийг дэмжих замаар дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийг	“Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх бодлого”-ын баримт бичгийн төсөлд Аймгийн тэргүүлэх ач холбогдол бүхий жижиг, дунд үйлдвэрүүдийн жагсаалтыг гаргаж, доорхи үйлдвэрүүдийг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж хөгжүүлнэ. Үүнд:Мах боловсруулах үйлдвэрийг сэргээн засварлаж өргөтгөх, Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр хөгжүүлэх /Чацаргана, нэрс, аньс/, Эмийн ургамал боловсруулах болон рашаан савлах үйлдвэр байгуулах,	70

	нэмэгдүүлнэ.	Завханы улаан хальст сармисны тариалалтыг нэмэгдүүлж, сармисны ханд бэлтгэх үйлдвэр байгуулах, Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэр, Ноос, ноолуур гүн боловсруулах үйлдвэр байгуулах, Мод модон эдлэлийн үйлдвэрийг өргөжүүлэх Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг болно. Энэ онд Мах боловсруулах үйлдвэрийг сэргээн засварлаж үйл ажиллагааг эхлүүлээд байна.	
	2.1.4. Ноос, ноолуур гүн боловсруулах, барилгын ханын материалын үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлнэ.	Ноос, ноолуурыг гүн боловсруулах зорилтын хүрээнд аймагт “Завхан ноосны чадавхийн төв” ТББ 2010 оны 05 дугаар сард байгуулагдан, ноосны сургалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болон ноосны лабораторийг ажиллуулж байна. Аймагт ноосны нэмүү өртгийн сүлжээ бий болгох, сүлжмэлийн 2 цех үйл ажиллагаа явуулж, сартуул хонины ноосон Брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх эхлэл тавигдаж байна. Аймагт жилдээ 1500 тн ноос угаах хүчин чадал бүхий үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэн суурилуулаад байна. Үүнийг түшиглээд ноосыг гүн боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мөн орон нутгийн нөөц боломжид тулгуурлан тоосго, блок зэрэг барилгын ханын материалын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх бодлого баримтлан дээрхи чиглэлийн үйлдвэрлэлийг төсөл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжин ажиллаж байна.	70
	2.1.5. Хөдөөг үйлдвэржүүлэх нэгдсэн бодлогын хүрээнд зах зээлд өрсөлдөх чадвартай, шинэ технологид суурилсан, жижиг, дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлнэ.	Аймаг орон нутагтаа эхний ээлжинд тэргүүлэх салбар болох мах, жимс, жимсгэнэ,эмийн ургамал боловсруулах болон рашаан савлах,сүү сүүн бүтээгдэхүүн, ноос, ноолуур гүн боловсруулах, мод модон эдлэл, барилгын материалын үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх бодлого баримтлан, 2009, 2010 онуудад дээрхи салбарын үйлдвэрүүдэд ЖДҮ-ийг дэмжих сангийн нийт зээлийн 70 орчим хувийг олгосон болно.	70
	2.1.6.Бие даан бизнес эрхлэх мэдлэг, чадвартай боловсон хүчин /үйлдвэрлэгч/-ийг сургаж дадлагажуулах, төсөл хөтөлбөрт хамруулах, гадаад улс орнуудад туршлага судлуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулна.	Аймагт үйл ажиллагаа явуулж буй Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын программд анхаарч, орон нутгийн тэргүүлэх салбарын үйлдвэрүүдэд ажиллах инженер, техникийн ажилтанг сургаж бэлтгэх, сургалтын байгууллага, үйлдвэрлэл хоёрын уялдаа, үйлдвэрлэлд ажиллах боловсон хүчний хэрэгцээ, шаардлагын талаар орон нутагтаа ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулж байна.	70
	2.1.7. Шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжиж, гэр хорооллын хэрэглэгчдийг утаа багатай түлшээр хангах ажлыг хэрэгжүүлнэ.	Аймагт шахмал түлшний жижиг 2 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа нь аймгийн төвийн гэр хорооллын хэрэглээний 10 хүртэл хувийг эзэлж байна. Аймагт өндөр хүчин чадалтай технологи бүхий шахмал түлшний үйлдвэрлэлийг төсөл хөтөлбөрийн хүрээнд дэмжих бодлого барьж байна. “Эмблем” ХХК, иргэн Гүррагчаа нар Улиастай сумын Өлзийт, Жаргалант багийн нутагт туршилтын шугамаар аргал, нүүрсний нунтаг, модны үртэс зэргийг ашиглан шахмал түлшний үйлдвэрлэлийг явуулж, тус багийн 200 гаруй иргэдэд нийлүүлж байна.	70
	2.1.8.Өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж шаардлагатай гарын авлагаар хангана.	Аймагт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэлийн 80-90 хувь нь өрхийн үйлдвэрлэл эрхэлж байна. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг ЖДҮ-ийг дэмжих төвтэй холбох, үйлдвэрлэлийг өргөжүүлэх, орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн байгууллагатай холбохын зэрэгцээ, үйлдвэрлэлээ өргөжүүлэх, хөгжүүлэх төсөл бичих гарын авлага бэлтгэж олгож байна.	70
<b>ДҮН</b>			<b>62,5</b>
<b>2.2. АЮУЛГҮЙ</b>	<b>ХҮНСНИЙ БАЙДАЛ,</b>	2.2.1.Гол нэрийн зарим бүтээгдэхүүний хэрэгцээг	Мах, сүүний фермерийн аж ахуйг эхний ээлжинд дэмжин хөгжүүлэх зорилт тавин 2009 онд фермерийн 11 иргэн, аж ахуйн нэгжид 112.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.
			70

<b>ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГО</b> Аймгийн хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг хангах, экологийн цэвэр бүтээгдэхүүн бий болгох нь хүнсний бодлогын зорилт болно.	дотоодын үйлдвэрлэлээр хангах, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, Завханы брэндийг бий болгож, гадаад, дотоод зах зээлд сурталчилна.	Мөн аймгийн 11 суманд цэврээр үржиж буй сартуул үүлдрийн хонины ноосоор эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар Нэхмэлийн хүрээлэн, ноос ноолуурыг дэмжих сан, Ноос ноолуурын холбоотой хамтран ажиллаж, ноосны чиглэлийн 6 үйлдвэрлэгчийг УБ, Дархан, Эрдэнэтийн үйлдвэрүүдээр туршлага судлуулах аялал, сургалт, семинарт оролцууллаа. Сартуул хонины ноосоор хийсэн бүтээгдэхүүнийг Завханы брэнд болгох зорилт тавин, үйлдвэрлэлийг өргөжүүлэх бодлого баримталж байна.	
	2.2.2.Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	2009 онд аймгийн хэмжээгээр 29615.0 л сүү нийлүүлэхээс 33120.6 л сүү нийлүүлж 111%, цагаан идээ 2456.0 тн нийлүүлэхээс 2873.9 тн-ыг нийлүүлж, бүтээгдэхүүн нийлүүлэлт 117 хувьтай байна. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж буй 4 иргэн, аж ахуйн нэгжид 56.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.	70
	2.2.3.Чацаргана тариалах хөдөлгөөн өрнүүлж, жимс, жимсгэнээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэдэд дэмжлэг үзүүлнэ.	2009 онд 5,8 га газарт чацаргана тариалж, Засгийн газрын “чацаргана” хөтөлбөрийн хүрээнд 20,0 мянган ширхэг чацарганы суулгацыг “Газрын шим”, “Завхан буудай” ХХК-уудаар дамжуулан 17 сумын иргэн, аж ахуйн нэгжид хуваарилан чацаргана тариалах арга хэмжээ авсан.	70
	2.2.4.Улиастайн мах боловсруулах үйлдвэрт хийгдэх техник, технологийн шинэчлэлийг дэмжинэ.	Аймгийн төвийн Мах боловсруулах үйлдвэрийг “Завхан хүнс групп” ХХК сэргээн засварлаж, 2010 оны 09 дүгээр сард ашиглалтанд оруулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор үйлдвэрийн нээлтийн арга хэмжээг хамтран зохион байгуулж, энэ үеэр аймгийн Малчдын зөвлөгөөнийг зохион байгуулж, мах боловсруулах үйлдвэрийн түүхий эд бэлтгэл, мал махны гэрээг малчидтай хийх ажлыг холбож өгсөн. МБҮ байгуулагдсанаар 100 гаруй хүнийг ажлын байраар хангаж, энэ онд 1000 гаруй бод, 5000-аад бог үйлдвэрийн аргаар бэлтгэн нөөцлөөд байна.	100
	2.2.5.Баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.	Аймагт иоджуулсан давсны 2 үйлдвэр үйл ажиллагаа явуулж, аймгийн иоджуулсан давсны хэрэгцээг бүрэн хангаж байна. Дээрхи 2 үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжиж сум багт хүргэх, түгээх талаар аймгийн иод дутлын эмгэгтэй тэмцэх хөтөлбөрийн баг, өрхийн эмч нар хамтран ажиллаж байна. Аймгийн ЭМГ-ын судалгаагаар иоджуулсан давсны хэрэглээ 95 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна. Мөн орон нутагт байгуулагдсан гурилын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг баяжуулах техник, технологийг судалж байна.	90
	2.2.6.Хүнсний бүтээгдэхүүний чанарын баталгааг тогтоох лабораторуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүнсний бүтээгдэхүүн, ундны усны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах хяналт, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгоно.	МХГ, МЭАЦЛабораторид бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүн болон Улиастай суманд худалдаалагдаж буй малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг МЭАЦЛ-ийн шинжилгээнд улирал тутам хамруулж, дээрхи бүтээгдэхүүний хариу дүгнэлтийг тухай бүр гаргаж байна. Бүс нутгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ноосны бүтцийг шинжлэх 14.0 сая төгрөгийн өртөг бүхий WilVint маркийн лабораторийн тоног төхөөрөмжийг нийлүүлж, 11 сумын сартуул омгийн хонины ноосыг шинжилж байна. Төв суурингийн ундны усны эрүүл, аюулгүй байдлыг хангах зорилгоор аймгийн 9 суманд ус цэвэршүүлэх төхөөрөмж сууриллууллаа.	70
	2.2.7.Хүнсний үйлдвэрлэл болон үйлчилгээний байгуулагуудыг цэвэр бохир усны магистрал сүлжээнд холбох ажлыг зохион байгуулна.	Улиастай сумын хүнсний үйлдвэрүүд болон ахуйн үйлчилгээний салбаруудыг “Амь-Ус трейд” ХХК-тай хамтран цэвэр бохир усны нэгдсэн сүлжээнд холбох ажлыг зохион байгуулж, 2009 -2010 онд 30 гаруй үйлчилгээний цэг салбар хамрагдаад байна.	50
<b>Худалдаа, үйлчилгээний салбарт</b>	2.2.8.Иргэдэд үйлчилгээг ойртуулах зорилгоор шинээр	Улиастай хотын Ерөнхий төлөвлөгөөг үндэслэн үйлчилгээний шинээр баригдаж буй цэг салбаруудыг Чигэстэй, Өлзийт, Жаргалант, Товцог зэрэг захын гэр хорооллуудад барих,	70

технологийн шинэчлэл хийж, экспортын болон хил худалдааг өргөжүүлэх бодлого баримтална.	баригдах үйлчилгээний цэгүүдийг айл өрх төвлөрсөн захын хороололуудад барих асуудлыг шийдвэрлэнэ.	өрхийн үйлдвэрлэлийг түлхүү дэмжих бодлого баримталж байна. Улиастай сумын Жаргалант, Чигэстэй багийн нутаг дэвсгэрт шинээр 2 хүүхдийн цэцэрлэг барьж ашиглалтанд орууллаа. Мөн айл өрх төвлөрсөн дээрхи багуудад худалдаа, үйлчилгээний 5 цэг салбар шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Мөн Чигэстэй, Өлзийт багуудад уст цэг шинээр барьж ашиглалтанд орууллаа. Орон нутагт үйл ажиллагаа эхэлж буй фермерийн аж ахуйг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөр малтай хороонд худаг шинээр гаргасан.	
	2.2.9.Улиастай суманд ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан, стандартад нийцсэн “Худалдаа үйлчилгээний төв” байгуулна.	Аймагт худалдаа үйлчилгээний төв байгуулах зорилгоор улсын төвлөрсөн төсвийн 500,0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл авч, Улиастай сумын Богдын гол багийн нутаг дэвсгэрт “Худалдаа үйлчилгээний төв” –ийн барилгын ажлыг “Засагт хан –Андууд” ХХК гүйцэтгэж барилгын ажил 30 хувьтай байна.	30
	2.2.10.Арц суурь боомтын материаллаг баазыг бэхжүүлэн, байнгын ажиллагаатай олон улсын чанартай болгож, хилийн худалдаа үйлчилгээг өргөжүүлэн яармаг худалдааг тогтмолжуулна.	Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдний зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх зорилгоор “Арцсуурь” хавар, намрын хилийн үзэсгэлэн яармагийг жилд 2 удаа амжилттай зохион байгуулж, тус яармагт Завхан аймгийн бүх сумд төдийгүй Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ, Төв, Архангай, Хөвсгөл, Увс, Ховд аймгийн бизнес эрхлэгчид оролцож бараа бүтээгдэхүүнээ борлуулж, ОХ-ны Тыва улсаас яармаг бүрт 2600-3000 бизнес эрхлэгчид, худалдан авагчид тус яармагуудад оролцлоо. Дээрхи худалдаанд монгол гэр, гэрийн эсгий, хивс, гэр ахуйн цахилгаан бараа эрэлт ихтэй байлаа. Арцсуурь боомтод худалдааны баталгаат агуулах барьж ашиглалтанд оруулсан.	90
	2.2.11.“Нэг суурин-нэг бүтээгдэхүүн” хөтөлбөрийн хүрээнд аймаг, сумын брэнд бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоно.	Жил бүр уламжлал болгон үзэсгэлэн яармагууд зохион байгуулж, олон номинациар бүтээгдэхүүн үйлчилгээг шалгаруулж урамшуулснаар сум, орон нутагт брэнд бүтээгдэхүүн бий болж, цаашид үйлдвэрлэлийн цар хүрээ өргөжих, “Нэг сумд-нэг бүтээгдэхүүн”, “Нэг байгууллагад-нэг бүтээгдэхүүн”, үйлчилгээ нэмэгдэж байна. “Завхан түншлэл”, “Баруун бүс түншлэл-2009”, улсын “Намрын ногоон өдрүүд-2009” нэгдсэн арга хэмжээ, “Арцсуурь-2009” хавар, намрын үзэсгэлэн яармагуудад аймгийн үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг зохион байгуулалттай оролцууллаа.	70
	2.2.12.Экспортод гаргаж буй хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, боловсруулсан ноос, ноолууран бүтээгдэхүүн экспортлоход дэмжлэг үзүүлнэ.	ОХУ-ын Тыва улс руу үйлдвэрийн аргаар боловсруулсан мах гаргахын зэрэгцээ үржлийн болон таваарын мал хөлөөр нь гаргах ажлыг зохион байгуулж эхлээд байна. Үүнтэй холбогдуулан малыг шинжилгээнд хамруулах зориулалттай малын хашаа, хүлээлгийн функтийг барьж ашиглалтанд орууллаа. Ноосоор хийсэн бэлэг дурсгал, гэрийн шаахай, ширмэл ширдэг болон монгол гэрийн эсгийг экспортлоход дэмжлэг үзүүлсэн.	70
2.2.13.Өргөн хэрэглээний барааны тогтвортой нөөц бүрдүүлж, худалдаа үйлчилгээнд шинэ дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлнэ.	Аймгийн хэмжээний өргөн хэрэглээний барааны үлдэгдэл, нөөц бүрдүүлэлт, үнийн судалгааг тогтмол гаргаж сар бүр ХХААХҮЯ-д хүргүүлж байна. 2009-2010 онд шинээр супермаркет дэлгүүр 8 байгуулагдаж, “Улиастай” зочид буудлын засвар тохижилтын ажил хийгдэж ашиглалтанд орлоо.	70	
<b>ДҮН</b>			<b>76,7</b>
<b>2.3. ДЭД БҮТЭЦ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО</b> Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй, газар зохион байгуулалтын төлөвлөлтийг	2.3.1.Сумдын халуун усны хүрэлцээ хангамж, нөхцөл байдалд шинжилгээ хийж, зайлшгүй шаардлагатай сумдын халуун усны барилгыг засварлах, шинээр барих асуудлыг ээлж дараатай	2009 онд аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Сантмаргац, Завханмандал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Сонгино, Цэцэн-Уул, Ургамал сумдын халуун усны барилгын засварын ажлыг тусгуулж, барилгын засварын ажлын санхүүжилтийг ТА-2 төслөөс дэмжиж, ажлын тоо хэмжээг газар дээр нь хэмжилт хийж, зураг төсвийг бэлэн болгож, тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг гүйцэтгүүлэн ашиглалтанд орууллаа.2010 онд Баянтэс сумын халуун усны барилгыг ТА-2 төслийн хөрөнгөөр барьж бүх сумд халуун усны барилгатай болсон.	100

сайжруулж, иргэдийг орон сууцаар хангах, инженерийн шугам сүлжээг өргөтгөх арга хэмжээ авах нь энэ салбарын гол зорилт болно.	шийдвэрлэнэ.		
	2.3.2.Газар зохион байгуулалт, газар олголтыг хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу эзэмшүүлж, ашиглуулан газрын харилцааны талаар гарсан хууль тогтоомжийг сурталчилж хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.	Газар зохион байгуулалтын болон газар олголтыг хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу тухайн оны ГЗБТ боловсруулах, төлөвлөгөөний биелэлтийг гаргах, ГЗБТ яаж боловсруулах, заавар зөвлөгөө өгөх, газрын тухай багц хууль болон газар өмчлөлийн талаарх ЗГ-аас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлт явц, газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлэх энэ талаар гарсан зөрчил дутагдалыг илрүүлж, арилгуулах гарч буй зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, хуулийг сурталчилах, сум бүрийн эзэмшигч, ашиглагч, өмчлөгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагын судалгааг гаргуулах, газар өмчлөгч, ашиглагч эзэмшигч нарийн бүртгэлийн дэвтэрийг нэг бүрчлэн бүртгүүлэх, газар эзэмших, ашиглах гэрчилгээний зарцуулалтыг номер, дугаараар нь тулган тооцоо хийж баталгаажуулах, газрын төлбөрийн талаар нэгдсэн ойлголт өгөх, газарт, дахин шалгалт, хэмжилт хийж зөрчилтэй газруудын судалгаа гаргах зэрэг ажлуудыг хийлгэж, зөрчлийг арилгуулах талаар анхаарч ажиллаж байна.	50
	2.3.3.Бүх сумдыг кадастрын зураглалд хамруулж, геодези зураг зүйн мэдээллийн санг бүрдүүлж бүртгэлжүүлнэ.	ГХГЗЗГ-аас зарласан Завхан аймгийн бүх сумдын кадастрын зураг хийх тендерт шалгарсан "ТОП КАД", "Мон-Мейл", "Асмей-Мон" ХХК мэргэжлийн байгууллагууд сумдын кадастрын зураглалыг хийж дуусгалаа. Аймгийн хэмжээний геодези, зураг зүйн талаарх мэдээллийг агуулсан мэдээллийн санг бүрдүүлж байна. Зарим кадастрын зураглалын өөрчилөлтийг тухай бүр нь хийж гүйцэтгэж дууссан.	100
	<p>3.1.4. Батлагдсан хууль тогтоомжийг иргэдэд цаг алдалгүй хүргэх, эрх зүйн албан бус сургалтыг мэргэжлийн үндсэн дээр зохион байгуулах ажлын цар хүрээ, хүртээмж, чанар үр нөлөөг дээшлүүлнэ.</p>	<p>Төрийн үйл ажиллагааны хүрээнд хууль тогтоомж, эрх зүйн актад гарсан өөрчлөлт, шинээр батлагдан мөрдөгдөж байгаа нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээнүүдийг тухай бүрт нь иргэдэд байгууллагын мэдээллийн самбарт байршуулах, байгууллагын мэдээллийн цагаар тайлбарлах хэлбэрүүдээр нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал: Шинээр батлагдсан 9 хууль шинэчлэн найруулагдсан 1 хууль, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Аймгийн Засаг даргаас гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг мэдээллийн самбарт байршуулан иргэдэд танилцууллаа. Сар бүр орон нутгийн “Этүгэн” телевиз, Хөгжимт жүжгийн театартай хамтарч “Хуулийн цаг” теле зохиомж хийж, “Эрх зүйн хөтөч” номноос сум бүрт 2 ширхэг, Таны туслах “Цэнхэр ном”-г 22000 ширхэг хэвлүүлэн өрх бүрт хүргүүлэн ажиллаа. Эрх зүйн сургалтын хүрээнд Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 150 оюутанд “Архи, түүний хор хөнөөл” сэдвээр яриа таниулага хийж, оюутан сурагчдын санал бодлыг сонсож цаашид ямар сэдвээр ярилцах талаар тодруулсны үндсэн дээр “Тамхи эсвэл эрүүл мэнд” сэдэвт уулзалт ярилцлагыг зохион байгуулж, АДРА Монгол ОУБ-ын Тамхины эсрэг Эрүүл мэндийн боловсрол төслөөс хэвлүүлсэн Тамхины тухай солонгос киног үзүүлж, тамхины хор хөнөөлийг сурталчиллаа. Нэгдсэн эмнэлгийн 42 сувилагч, тусгай мэргэжилтэнд “Хөдөлмөрийн эрх зүй харилцаа ба чалин хөлс”, аймгийн Хөгжимт жүжгийн театрын 53 ажилтанд “Төрийн албан хаагчийн баталгаа, урамшуулал” сэдвээр нийт 95 иргэнд сургалт зохион байгууллаа. Мөн сургалтанд хамрагдсан иргэдийн хүсэлтээр “Хөдөлмөрийн эрх зүйн харилцаа” сэдвээр аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран дахин сургалт зохион байгуулж, зөрчигдсэн эрхийн талаар шийдвэр гаргагч нартай уулзалт ярилцлага зохион байгууллаа. Мөн Үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд Цагдаагийн газрын 35 албан хаагчдад “Авлигаас урьдчилан сэргийлэх хамтран ажиллах нь”, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, нарийн бичгийн дарга, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, хөдөлмөр халамж үйлчилгээний ажилтан зэрэг 100 орчим албан хаагчдад “Хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах нь” сэдэвт сургалт, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2010 оны 67 дугаар тушаалаар баталсан “Эрх зүйн дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль сурталчлах нэг сарын, “Архидалтгүй-эрүүл амьдрал” хоёр сарын аян зарлан аймгийн Засаг даргын 153 дугаар захирамжаар батлуулан ажиллаж байна.</p>	90
	<p>3.1.5. Архивын баримт ашиглалт, хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, лавлагаа мэдээллийн ажлыг</p>	<p>Архивын ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг боловсронгуй болгох үүднээс архивын баримт, материал хадгалах стандарт хангасан орчин үеийн техник хэрэгсэл, байртай болгох боломжийг бүрдүүлж, үйлчилгээний нөхцөлийг сайжруулан энэ асуудлыг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлээд байна. Мөн Архивын</p>	70

	<p>орчин үеийн шаардлагын түвшинд хүргэж, архив, төрийн албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлнэ.</p>	<p>хадгалалт хамгаалалтыг сайжруулах үүднээс аймгийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй дуу, дүрс бичлэг, тоо бүртгэлийн баримт бичиг хадгалах 1 ком шүүгээ, тоо бүртгэлийн баримт бичиг хадгалах хэргийн шүүгээ 1 ком, ажлын хэрэгцээний 2 сэйф /1 593 000/ мянган төгрөгөөр худалдаж авсан. Архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх зорилгоор хөмрөг үүсгэгч болон төрийн байгууллагуудын 1999 оноос өмнөх онуудын байнга хадгалах баримтуудыг энэ онд багтаан төрийн архивт татан авч хөмрөгийн жагсаалт данс бүртгэлийг нягтлан шалгаж, шинэчлэх, шаардлагатай тоног төхөөрөмж техник хэрэгслэлээр хангах ажлыг хийж байна. Байгууллагын архивт мэдээллийн технологи нэвтрүүлэхээр 2010 оны аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган бэлтгэл ажлыг хийсэн.</p>	
<p><b>3.2.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОЖ БЭХЖҮҮЛЭХ</b></p>	<p>3.2.1.Улсын бүртгэлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагуудыг нэгтгэн зохион байгуулах замаар эрх зүйн бүртгэл /иргэн, хуулийн этгээд, үл хөдлөх эд хөрөнгө/-ийг нэг цэгт хийх нөхцөл боломжийг бүрдүүлж бүртгэл мэдээллийн ажлыг цахим хэлбэрт шилжүүлнэ.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2008 оны 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн Засаг даргын 2009 оны 158 дугаар Захирамжаар Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн Иргэний бүртгэл мэдээллийн алба, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн алба,Татварын хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэлийг нэгтгэн 2009 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс Улсын бүртгэлийн хэлтэс болгон шинээр зохион байгуулж, үйл ажиллагаа явуулж байна. Улсын бүртгэлийн хэлтэс нь нутгийн захиргааны ордонд байрлаж, төрийн нэг үлчилгээг хөнгөн шуурхай үзүүлж, улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлж байгаа нь зохиох үр дүнгээ өгч байна.Улсын бүртгэлийн үйл ажиллагааг байгууллагын 610 хадгаламжийн нэгж баримтыг татан авч нөхөн бүрдүүлэлт хийсэн. 2009 оны 07 дугаар сараас онлайн сүлжээнд холбон, улсын хэмжээнд нэгдсэн праграмм хангамжаар хангагдан, бүртгэлийн ажил цахим хэлбэрт бүрэн шилжсэн.</p>	100
	<p>3.2.2.Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрх болон түүнтэй холбоотой эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэн баталгаажуулж, иргэд, хуулийн этгээдийн эд хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцлийг бүрдүүлнэ.</p>	<p>Иргэдийн эд хөрөнгө, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг хангах, энэ харилцаанд гарч буй хүндрэл бэрхшээл, хураамж төлбөр өндөр байгаа талаар иргэдээс гаргасан санал хүсэлт, түүнийг шийдвэрлэх арга замын талаар Хууль зүй дотоод хэргийн сайдад аймгийн Засаг даргын албан тоотыг хүргэж, энэ асуудлыг шийдвэрлэхээр судалж байгаа талаар хариуг авсан. Энэ асуудлыг боловсронгуй болгох талаар Хууль зүйн хэлтэсээс орон нутгийн хэмжээнд төлбөр хураамж авдаг төрийн болоод төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Улсын бүртгэлийн хэлтэс нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг Улсын бүртгэлийн ерөнхий хууль, бусад төрөлжсөн хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан заавар журмын хүрээнд хийж байна. Улсын бүртгэлийн хэлтэс эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй холбоотой 20 шахам төрлийн бүртгэлийг хийж, иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой мэдээлэл сурталчилгааг олон хэлбэрээр хийсний үр дүнд эд хөрөнгөө Улсын бүртгэлд хамруулах үйл явц өсөх хандлагатай байна. Эд хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулахыг өргөжүүлэх ажлын хүрээнд арилжааны банкууд болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг Цахим хэлбэрт оруулах ажлыг эхлүүлээд байна.</p>	90
<p><b>3.3.ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ БОДЛОГО</b></p>	<p>3.3.1.Цагдаагийн ажил үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор Тосонцэнгэл сумын цагдаагийн хэсгийг хэлтэс болгон өргөтгөж, сумдад байнгын пост барьж байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулж кабон систем байртай</p>	<p>Цагдаагийн хэлтэс болгох тухай санал, холбогдох материалыг Цагдаагийн Ерөнхий газарт хүргүүлэн ажилласны дагуу Тосонцэнгэл сумын Цагдаагийн тасгийг хэлтэс болгон үйл ажиллагааг нь өргөжүүлэн ажиллаж байна. Тосонцэнгэлд хэлтэс байгуулснаар тухайн бүсийн сумдын иргэдэд цагдаагийн байгууллагын үйлчилгээг ойртуулах, түргэн шуурхай хүргэх бололцоог хангасан бөгөөд 2010 онд Нөмрөг сумд Цагдаагийн иж бүрэн кабон бариулаад байна. 2011 онд Завхамандал сумын Цагдаагийн хэсэг, Сантмаргаз сумдад цагдаагийн кабон бариулахаар санал хүргүүлээд байна.</p>	70

болгох асуудлыг ээлж дараатайгаар шийдвэрлэнэ.		
3.3.2.Сумдын хэсгийн төлөөлөгчийн унааны хангамжийг сайжруулна.	Сум бүрийн хэсгийн төлөөлөгчдийг авто машинаар бүрэн хангах ажлын хүрээнд 13 сумдын хэсгийн төлөөлөгчийг авто машинаар хангаж, аймгийн төвд хөдөлгөөнт эргүүлийн 4 машин нэмж унааны хангамжийг нэмэгдүүлж хэрэг, зөрчил багасгах ажилд дэмжлэг үзүүллээ.	90
3.3.3.Шүүхийн шинжилгээний алба байгуулж гэмт хэргийн ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийх лабораторийн техник хэрэгсэл, боловсон хүчнээр хангана.	МУ-ын ЗГ-ын 2007 оны 272 дугаар тогтоолын дагуу Завхан аймгийн Цагдаагийн газрын дэргэд 2009 оны 01 сарын 01–нээс “Шүүхийн шинжилгээний алба” байгуулан дарга, нягтлан бодогч, кримналистикийн шинжээч, шинжээч эмч, гарын хээний санч, үйлчлэгч, Тосонцэнгэл суманд кримналистикийн шинжээч, шинжээч эмч гэсэн орон тоотойгоор ажиллаж байна. ШШАлба нь эд мөрийн баримтад үзлэг шинжилгээ хийх, лабораторийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдан ажиллаж байна.	90
3.3.4.Террорист үйл ажиллагаа, хар тамхи, мансууруулах бодис худалдах, олж авах, хэрэглэх, садар самуунд уруу татах, хүн худалдаалах, байгалийн баялаг ашиглах, цианит мөнгөн ус хэрэглэх зэрэг шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудалд түлхүү анхаарна.	Террорист үйл ажиллагааг гаргахгүй байх, таслан зогсооход дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2010 оны 130 дугаар захирамжаар терроризмтай тэмцэх ажиллагааг зохиоцуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардалд зориулж 500 000 төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Зөвлөлийн гишүүдийн хурлаар өнгөрсөн жилийн тайланг хэлэлцэж, ирэх жилийн ажлын төлөвлөгөөгөө баталсан. Ховд аймагт Монгол Улсын ТТАЗЗ-өөс зохион явуулсан “Сөрөг тусгай ажиллагааны шуурхай штабыг байгуулах нь” сэдэвт сургалт семнарт салбар зөвлөлийн гишүүдийг оролцууллаа. Мөн Нисэх буудал, усан хангамжийн сан, иргэд олноор төвлөрдөг цэг салбаруудад зөвлөлийн гишүүдийг оролцуулсан хяналт шалгалт хийхээр болоод байна. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 4 дүгээр улиралд бусад шаардлагатай аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийх, сургалт зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.	70
3.3.5.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах ажилд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах, тэдгээрийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд онцгой анхаарна.	Улсын хилийн зөрчлийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, багасгах зорилгоор Тэс, Баянтэс сумдын иргэдийг хот айлын журмаар хилийн хамгаалалтад оролцуулан мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна. Үүний үр дүнд хил хамгаалалтад 93 туслах хүчин хамрагдаж үүнээс 11 гишүүн онцгой сайн ажиллаж отрядын зүгээс шагнагдаад байна. Аймгийн хэмжээнд 13 сумд тус бүр нэг, Улиастай сумд 4 ширхэг хөдөлгөөнт эргүүлийн авто машин хуваарилан 24 цагаар ажиллуулж байна. Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгох зорилгоор ГХУСАЗЗ, Хүчирхийллийн эсрэг төвийн салбар, хуулийн байгууллагуудын дунд Дэвжээ тэмцээн зохион байгуулахаар удирдамж батлуулан оролцох байгууллагуудад /Шүүх, Прокурор, Цагдаа, ШШГА/ хүргүүлээд байна. 12 сарын 1-ээс хүний эрхийг дээдэлж, хүчирхийллийн асрэг хамтдаа сарын аяныг аймгийн хүчирхийллийн эсрэг төвтэй хамтран зохион байгуулж аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сургалт сурталчилгаа, хэлэлцүүлэг, өдөрлөг зохион байгуулахаар төлөвлөж байна. Засаг даргын 215 дугаар захирамжаар гэр бүлийн хүчирхийллийн эсрэг чиглэсэн үйл ажиллагаа явуулах үүрэг зорилго бүхий төрийн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн хамтарсан баг байгуулсан. Хамтарсан баг нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, арга хэмжээ авч ажиллах юм. Энэ хамтарсан багийн үйл ажиллагааны хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл түүнээс үүдэлтэй бусад гэмт хэргүүдийн гаралтыг тоон үзүүлэлтээр бууруулах явдал юм.	70
3.3.6.Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймаг, сумын санд орон нутгийн төсвөөс жил бүр санхүүгийн дэмжлэг үзүүлж, мал хамгаалах	Мал, малын гаралтай түүхий эд борлуулдаг цэг салбар болон тээврийн хэрэгсэл дайран өнгөрөх гол зангилаа замуудад байнгын 4 пост ажиллаж байна. Мөн цагдаагийн газар, хууль зүйн хэлтсийн хамтарсан “Урт гар” хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж байгууллага, сургуулиудад хулгайн гэмт хэргийн талаар ухуулга сурталчилгаа хийх, сүүлийн 3 жилийн гэмт хэргийн ерөнхий судалгааг мэдээллийн самбарт	50

<p>малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхижүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авна.</p>	<p>байршуулах, үзэлээр тодорхой цагуудад зарлуулан сэрэмжлүүлэх, гарын авлага материал бэлдэж иргэдэд хүргэх арга хэмжээнүүдийг явууллаа. 2010 онд аймгийн Засаг даргын “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” 154 дүгээр захирамж гарган хэрэгжүүлээд байна.Захирамжийн хүрээнд төлөвлөгөө гаргуулан аймгийн Засаг даргаар батлуулан 2 сарын хугацаатай шөнийн эргүүл, хяналт шалгалт хийж байна.</p>	
<p>3.3.7.Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, архидан согтуурлын хор хөнөөлийг бууруулах ажлыг идэвхижүүлэн, согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түүгээр үйлчлэхэд тавих хяналтыг шинэ шатанд гаргаж, архинд донтох өвчтэй хүмүүсийг эмчлэх ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлнэ.</p>	<p>Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа үйлдвэрлэдэг, худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 162 цэг, салбар, дэлгүүр, 127 зоогийн газруудад 731 удаа үзлэг шалгалт хийж, 177 литр архи, согтууруулах ундааг хуулийн дагуу хураан авч, Засаг даргын 88 дугаар захирамжийн дагуу зоогийн газар 2, кафе 6, хүнсний дэлгүүрийн 37 цэг салбарын согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрлийг хүчингүй болгуулан ажиллаа.Мөн энэхүү үйл ажиллагааны хүрээнд 876 албан мэдэгдэл өгч, 832 хариу авч, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль” –иар нийт 1308 зөрчил илрүүлэн, 76 иргэнийг 233.000 төгрөгөөр торгож, биеэ авч явах чадваргүй 247 хүнийг ар гэрт нь хүлээлгэн өгч ажиллаа. Мөн “Архи ба жолооч”, “Хөдөлгөөний соел” зэрэг арга хэмжээ явуулж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 66 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 17 эрхийн үнэмлэхгүй жолоочид арга хэмжээ авч, хөтөлбөрийн хүрээнд 24 сумын 34000 мянган хүнд мэдээлэл өгч, 8 төрлийн 2400 ширхэг сэрэжлүүлэх, ухуулга хуудас тарааж, орон нутгийн 4 телевизээр сар бүр мэдээлэл хийж ажиллалаа.2010 оны 2 дугаар улиралд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Мэргэжлийн хяналтын газар, Улиастай сумын ЗДТГ, Хууль зүйн хэлтэс, Стандартчлал хэмжил зүйн хэлтэс хамтран Архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг цэг салбаруудад хяналт шалгалт хийлээ. Шалгалтанд нийтдээ 3 зоогийн газар, 7 кафе, 62 хүнсний дэргүүр хамрагдаж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч, анхааруулга, санамж өгч ажиллаа. Мөн Хууль зүйн хэлтсээс санаачлан “Архидалтын эсрэг хамтдаа” зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд 25 байгууллагын бодлого хэрэгжүүлэх чиглэлийн удирдан албан тушаалтнууд оролцсон. Зөвлөгөөнд аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Шүүх, Нэгдсэн эмнэлэг, ГХУСЗЗ, Өмгөөлөгчдийн зөвлөлөөс архидан согтуурах явдлын өнөөгийн нөхцөл байдал, шалтгааныг тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга замыг тусгасан илтгэлүүд хэлэлцүүлээ. Зөвлөгөөний үр дүнд аймгийн хэмжээнд Засаг даргын 03 тоот албан даалгавар гаргуулж, ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Архидан согтуурахтай тэмцэх тухай Аймгийн Засаг даргын 2010 оны 03 дугаар албан даалгаврыг эрчимжүүлэх, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2010 оны 67 дугаар тушаалаар баталсан “Эрх зүйн дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хууль сурталчлах нэг сарын, архидалтгүй – эрүүл амьдрал хоёр сарын аян зарлан аймгийн Засаг даргын 153 дугаар захирамжаар батлуулан ажиллаж байна. Эдгээр аяны хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтэс, Цагдаагийн газар хамтран олон нийтэд чиглэсэн арга хэмжээг зохиолгохоор “Архидалтын эсрэг оюунлаг гарц олцгооё, Архидалтгүй эрүүл орчин бүрдүүлцээ” уриан дор аймгийн төвийн 43 байгууллага, аж ахуйн нэгжээр 2010 оны 10.14-с 2011 оны 04.14-нийг дуустал аяны тууз, дэвтрийг аялуулж байна.</p>	90
<p>3.3.8.Хууль хамгаалах болон хэрэгжүүлэх байгууллагад ажиллаж байгаа ажилтнуудыг орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллахад нь бодит дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газраас хил хамгаалах туслах хүчний ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах, ахуй хангамжыг сайжруулах үүднээс Засаг даргын нөөц сангаас 4 сая төгрөгийг төлөвлөж өгсөн. Мөн цагдаагийн албан хаагчдыг сумдад тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг хангах үүднээс сум бүрт орон сууц, байраар хангах асуудлыг тухай бүр орон нутгийн төсөвт суулган хэрэгжүүллээ. Аймгийн Засаг даргын Тамгын газраас хил хамгаалах туслах хүчний ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах</p>	90

		нөхцөлийг хангах, ахуй хангамжыг сайжруулах үүднээс Засаг даргын нөөц сангаас 4 сая төгрөгийг төлөвлөж өгсөн.	
	3.3.9.Сумдын хэсгийн төлөөлөгч нарыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг хангах зорилгоор гэр, орон сууцны асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.	Сумдын Цагдаагийн албан хаагчдыг гэр орон, орон сууцжуулах ажил ээлж дараатай хийгдэж байна. Аймгийн 20 айлын сууцнаас цагдаагийн байгууллагад нэг айлын орон сууц олгохоор шийдвэрлэсэн.Нөмрөг сумд Цагдаагийн кабон бариулах асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Завханмандал сумын цагдаагийн хэсэг, Сантмаргаз сумд цагдаагийн кабон бариулахаар төлөвлөөд байна.	70
<b>3.4.ХИЛ ХАМГААЛАХ БОДЛОГО</b>	3.4.1.Хил хамгаалалтын үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн болон нутгийн захиргааны байгууллагуудыг өргөнөөр оролцуулж уялдаа холбоог бэхжүүлнэ.	Хил хамгаалах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор орон нутгийн цагдаагийн байгууллага,гааль, мэргэжлийн хяналтын багууллагатай нягт хамтран ажиллаж, шалган нэвтрүүлэх салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж байна. Мөн Орон нутгийн өрхүүдийг бүлгийн зохион байгуулалтад оруулж мэдээлэл дамжуулах бололцоогоор ханган, ажлын тайланг нь улирал тус бүрээр нь авч ажиллаж байна. Улсын хил хамгаалах туслах хүчний гишүүдийн цугларалтыг 2009 оны 09 дүгээр сард зохион байгуулж сургалт, зөвөлгөөн хийсэн. Цугларалтын үеэр бүх гишүүд хил хамгаалалтанд оролцох өдөр тутмын хуваарь, ажлын төлөвлөгөө, журам боловсруулан гаргалаа. Уулзалт зөвөлгөөнд 93 туслах хүчний гишүүн оролцсоноос хил хамгаалалтад идэвхи зүтгэлтэй оролцсон 11 гишүүнийг отрядын зүгээс шагнаж урамшууллаа.Аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хил хамгаалах туслах хүчний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр 5 сая төгрөгийг төсөвлөн санхүүжүүлээд байна.	70
<b>3.5.ГАМШИГ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГО</b>	3.5.1.Бүх сумдад гамшиг осол болон галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж, гамшиг ослын үед дуудлагаар ажиллахад шаардагдах хөрөнгийн нөөц сантай болгоно.	Гал түймэр, гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажлын төлөвлөгөө гарган Тэс, Баянтэс, Баянхайрхан, Асгат, Нөмрөг, Түдэвтэй, Идэр, Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул, Завханмандал, Эрдэнэхайрхан, Дөрвөлжин, Ургамал гэсэн 14 суманд 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 05 дугаар сарын 01-ийг хүртэл хугацаанд Засгийн газрын 02, Онцгой байдлын Ерөнхий газрын 01, аймгийн Засаг даргын 02 дугаар албан даалгавруудын биелэлтийг шалгах, ой, хээр, объектын түймэр, шар усны үерээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, заавар, зөвлөмж өгөх, сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд 500.0 төгрөг зарцууллаа. 2009-2010 онд тус хэлтсийн бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгагдсаны дагуу аймгийн Баянхайрхан, Баян-Тэс, Асгат, Нөмрөг, Цэцэн-уул, Сантмаргаз, Тэлмэн, Сонгино, сумдад гамшгаас хамгаалах Команд штабын сургуулийг,үзлэгийг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу 04 сарын 08-17, 06 сарын 14-16 ны хооронд зохион явуулж, сургууль үзлэгээр, сумдын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, онцгой комисс, штаб, алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг, зарлан мэдээлэх журмын дагуу шалган, цагийн байдал өгч болзошгүй гамшиг ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ажиллах төлөвлөгөө гаргуулан, сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдхүүнээр тактикийн дадлага сургуулийг биечлэн хийлгэсэн. Монгол улсын засгийн газрын 02 тоот, ОБЕГ-ын даргын 01 тоот албан даалгаврын хүрээнд аймгийн Засаг даргын албан даалгавар гаргуулан Тэс, Баян-тэс, Баянхайрхан, Асгат, Түдэвтэй, Нөмрөг, сумдын албан газар, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч, гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн бүрэлдхүүнийг оролцуулан 6-н сумын 277 хүнд ой хээрийг түймрээс хамгаалах, шар усны аюулаас урьдчилан сэргийлэх, объектын түймрээс урьдчилан сэргийлэх, гамшигийн үеийн холбоо зохион байгуулалт зэрэг сэдвүүдээр 18 цагийн сургалтыг зохион явуулсан нь үр дүнтэй боллоо.	50
	3.5.2.Онцгой байдлын хэлтэс,		10

	Гамшгаас хамгаалах албад мэргэжлийн ангиудыг хээрийн нэгдсэн сургалтад хамруулж байх үүрэг зориулалт бүхий талбай байгуулж, сургалтын техник хэрэгслээр хангана.	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд санал оруулахаар төлөвлөөд байна.	
	3.5.3.Онцгой байдлын хэлтсийн ажилтан, албан хаагчдыг ажиллах нөхцөл боломжоор хангах зорилгоор орон сууцаар хангах ажлыг ээлж дараатай шийдвэрлэнэ.	“40 айлын орон сууц” хөтөлбөрт Онцгой байдлын хэлтсийн орлогч, ажлын албаны дарга т/а Ө.Болд, Дуудлага хүлээн авагч оператор д/т Ж.Ганчимэг нарын алба хаагчид хамрагдан орон сууцтай болсон.	70
<b>ДҮН</b>			<b>77,0</b>
3.6.ИРГЭНИЙ НИЙГЭМ, ТӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг боловсронгуй болгох шаардлагатай арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэхийн хамт, иргэний нийгэм, төрийн байгууллагын түншлэл, тогтвортой үйл ажиллагаа, ил тод байдал, төрийн албаны ур чадвар, хариуцлагын тогтолцоог өндөржүүлэх нь энэ салбарын зорилт болно.	3.6.1.Аймагт үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлж, түншлэлийг хөгжүүлнэ.	Аймгийн эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын Өрнөх хөгжил сүлжээтэй аймгийн Засаг дарга гэрээ байгуулан аймгийн Засаг даргын 2008, 2009 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хамтран мониторинг хийлээ.	50
	3.6.2.Төр иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлж, шийдвэр гаргах, бодлого боловсруулахад тэдний оролцоог нэмэгдүүлнэ.	Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын дарга нар иргэдэд тайлангаа хэлэлцүүлж, тэдний санал хүсэлтийг сонсож, байгууллагуудын хөтөлбөр төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газраас 2009 онд төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээг шуурхай болгох, хүнд суртал чирэгдлийг багасгах, төрөөс үйлчилгээ авахдаа олон шат дамжлагыг арилгах, тэдний хууль зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх үүднээс иргэдийн өдөр тутмын хэрэглээнд зориулж “Таны туслагч Цэнхэр ном”, 2010 онд бизнесийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн “Таны туслагч Шар ном”-ыг хэвлүүлэн бүх өрхийн тоогоор тараан хэрэглүүлж хэвшээд байна. Аймгийн эмэгтэйчүүдийн Өрнөх хөгжил сүлжээ нь эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд төр олон нийт иргэний нийгмийн байгууллагын оролцоо сэдэвт бодлогын баримт бичиг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж асуудал дэмжигдсэн.	70
	3.6.3.Нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангасан иргэнд үйлчлэх үндсэн чиг үүрэг бүхий цомхон, чадварлаг, хариуцлагатай төрийн албыг хөгжүүлнэ.	Монгол Улсын Засгийн газраас нутгийн захиргааны байгууллагын бүтэц орон тоог баталсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлаг, бүх сумдын ЗДТГ-ын бүтэц орон тоог хүн амын тоо, суурьшилтай нь уялдуулан шинэчлэн боловсруулах, цомхон чадварлаг төрийн албыг бэхжүүлэх, хариуцлагатай төрийн албыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.	70
	3.6.4.Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлж, хууль дээдлэх, авилгыг үл тэвчих ухамсар, зан үйлийг төлөвшүүлж, ажиллах нөхцөл, баталгааг бүх талаар хангана.	Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, ажлын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр Засгийн газрын “Сахилга, дэг журам, хариуцлагыг дээшлүүлэх тухай” 2009 оны 03 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын төрийн байгууллагуудын үйл ажиллагаа дотоод хяналтыг сайжруулах 01 тоот албан даалгаврыг аймгийн хэмжээний бүх төрийн байгууллагууд, сумдад хүргүүлэн биелэлт үр дүнг тооцон ажиллаж байна.	70

<p>3.6.5.Бодлого үйл ажиллагааны явц, үр дүнд хийх хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхи үр нөлөөг дээшлүүлнэ.</p>	<p>Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргыг Тамгын газрын даргын тушаалаар Хяналт шинжилгээ үнэлгээний тасаг шинээр байгуулагдан аймгийн Засаг даргын захирамжаар ажиллах дүрэм журмаа батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээ”, “Хяналт шинжилгээ үнэлгээ хийх онол, арга зүй” сэдэвт семинарт хяналт, шинжилгээ үнэлгээний тасгийн дарга хамрагдлаа. Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоол, 160 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 85, 127 дугаар захирамжийг үндэслэн ажиллаж байна. Засаг даргын дэргэдэх хэлтэс агенлагуудад аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу хяналт шинжилгээ үнэлгээ хийж, цаашид анхаарах асуудлуудаар зөвлөмж хүргүүлж ажиллалаа. Мөн төрийн байгууллага, аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа дотоод хяналтыг сайжруулах тухай аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаврыг гаргаж төрийн байгууллагуудад мөрдүүлж байна.</p>	<p>70</p>
<p>3.6.6.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг боловсронгуй болгох, арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн II хуралдаанаар Тэлмэн сумын төвийн багийг шинээр байгуулж, Түдэвтэй сумын хөдөөгийн багийн төвийг сумын төвийн баг болгон нэгтгэж өөрчлөн зохион байгууллаа.</p>	<p>70</p>
<p>3.6.7.Засаг захиргааны анхан шатны нэгж багийн хөгжлийг дэмжих Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.</p>	<p>“Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 үе шаттайгаар боловсруулан хэрэгжүүлж байна. 2007-2010 оны аймгийн Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлүүдэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх тодорхой ажлуудыг тусган биелэлтийг тооцон ажиллаж байна. “Багийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр”, төлөвлөгөөний биелэлтийг хангуулах ажлын хэсгийг сумын Засаг дарга, ИТХ-ын шийдвэрээр сум бүрт байгуулан ажиллуулж, энэ ажлын хүрээнд хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж заавар зөвлөгөө өгч ажиллаж байна. 2009 онд хөтөлбөрийн 2007-2009 оны биелэлтийг батлагдсан зааврын дагуу гаргаж ЗГХЭГ-т хүргүүллээ. 2010 оныг аймгийн Засаг даргаас 2010 оныг “Сумдын тохижилт бүтээн байгуулалт, үйлдвэржилтийн жил” болгон зарлаж, хөтөлбөр, төлөвлөгөө батлан хэрэгжүүлж эхний 11 сарын ажлын мэдээллийг авч, дүгнэлт гаргалаа. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу хөдөөгийн 88 багт “Төрийн цогц үйлчилгээг багт хүргэх” чиглэлээр багийн иргэд, нийтийн хурал өдөрлөгийг зохион байгуулан 3 шатны Засаг дарга нарын тайланг тавиулж, иргэдэд нийгмийн халамж, даатгал, эрүүл мэнд, боловсрол, соёл урлагийн чиглэлээр цогц үйлчилгээ үзүүлж ажиллаа. Багийн иргэд, малчдын санал, хүсэлтийг сонсож, хийж хэрэгжүүлж буй ажлуудаа тайлагнан багийн Засаг дарга нарын ажиллах нөхцөл бололцоог нь дээшлүүлэхийн тулд уналгын морь, ажлын цүнх гардууллаа. Бүх багийн эмч нарын уналгын асуудлыг шийдлээ. Энэ үеэр иргэдээс гаргасан санал, хүсэлтийг нэгтгэн тусгай төлөвлөгөө гарган холбогдох газруудад уламжлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p>	<p>90</p>
<p>3.6.8. 40 мянган айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд улсын болон хувийн хэвшлийн орон сууц барих асуудлыг</p>	<p>40000 айлын орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Улиастай 200” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2009 онд Улиастай суманд бага дунд орлоготой залуу гэр бүлд зориулсан 30 айлын орон сууц баригдаж ашиглалтанд орсон бөгөөд 2010 онд төрийн албан хаагчдад зориулсан 20 айлын орон сууц баригдаж барилгын гүйцэтгэл 80 хувьтай байна.</p>	<p>50</p>

	дэмжинэ.			
	3.6.9.Иргэний байгууллагуудын чуулганыг зохион ажил төрлийн сайжруулан ажиллана.	нийгмийн аймгийн байгуулж холбоог	Баруун бүсийн аймгуудад шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой зөвлөлдөх уулзалтыг Улиастай хотод зохион байгууллаа. Зөвлөлдөх уулзалтанд Завхан, Говь-Алтай, Увс аймгийн 50 гаруй эмэгтэйчүүдээс гадна Монголын Эмэгтэйчүүдийн сангийн захирал Н.Чинчулуун, УИХ-ын гишүүн асан, Жендэрийн тэгш байдлын тухай болон Сонгуулийн тухай хуулийн ажлын хэсгийн гишүүн Б.Мөнхтуяа нар оролцов. Энэхүү уулзалтанд оролцож буй эмэгтэйчүүд 1.Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо ба шийдвэр гаргах түвшин дэхь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх боломж, 2.Шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудлууд, 3.Шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийг бэлтгэх нь гэсэн гурван чиглэлээр салбар хуралдаан хийлээ. Мөн “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагуудын оролцоо” сэдэвт чуулган зохион байгуулж, Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд төрийн бус байгууллагуудын оролцоог хангах чиглэлээр зөвлөмж гаргасан. Энэхүү чуулганд сумдын ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга нар хамрагдаж, “Эмэгтэйчүүдийн “Өрнөх хөгжил” ТББ, Үйлдвэрчний эвлэл, Өмгөөлөгчдийн салбар зөвлөл, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн салбар, ГХУСАЗЗөвлөл, Залуучуудын холбооноос илтгэлүүд тавьж хэлэлцүүлсэн.	70
	3.6.10.Аймгийн асуудлаар судалгаа хурал зөвлөгөөн байгуулахад иргэдийн санаачлагын өргөн ажиглалт хамруулж хамтарч ажиллана.	хөгжлийн явуулах, зохион үүсгэл байгууллагуудыг хамтарч	Аймгийн Засаг даргын санаачлагаар аймгийн Засаг даргын Тамгын газар, Завхан аймгийн нутгийн зөвлөл, сумдын нутгийн зөвлөл, Сумдын Засаг даргын Тамгын газар, Завхан нутгаас төрсөн гарсан улс төрийн зүтгэлтэн, бизнесменүүд хамтран аймгийн хөгжлийн чуулга уулзалтыг зохион байгуулсан. Аймгийн эдийн засаг нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсаны дагуу ядуурал, амьжиргааны түвшингийн судалгааг явуулах аймгийн комисс байгуулагдан аргачлалыг боловсруулан сумдад сургалт зохион байгуулж, судалгааг явуулж байна.	70
	3.6.11.Аймаг, сум, багийн хөгжлийн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.	багийн	Эрчимтэй хөгжлийн Завхан сангийн журмыг 2008 онд батлан 2010 оны 11 сарын 01-ний байдлаар 692,6 сая төгрөг төвлөрүүлэн 608,9 төгрөгийн гүйцэтгэл гарч үр дүнг аймгийн ИТХ-д танилцуулж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан ажиллаж байна.	50
	3.6.12.Сумдын Тамгын газрын барилгыг шинээр засварлах ажлыг дараатай шийдвэрлэнэ.	Засаг даргын конторын барилгыг шинээр барих буюу засварлах ажлыг ээлж	2009 онд Аймгийн ЗДТГ-ын байр, Баянтэс сумын ЗДТГ-ын байр, Дөрвөлжин сумын Онц багийн Төрийн үйлчилгээний ордонг, 2010 онд Баянтэс сумын ЗДТГ-ын байрыг барьж дуусган ашиглалтанд хүлээн авлаа. 2010 онд Цагаанхайрхан сумын ЗДТГ-ын барилгын засвар, Нөмрөг, Сонгино сумдын ЗДТГ-ын барилгын халаалтын зуухны засвар шинэчлэлтийн ажлыг хийж техникийн комиссоор хүлээн авсан. Завханмандал сумын ЗДТГ-ын конторын барилга барих ажил хийгдэж байна.	70
<b>ДҮН</b>			<b>71,2</b>	
<b>ДӨРӨВ.ИРГЭДИЙНХЭЭ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ, ГАДААД ХАРИЛЦААГ ӨРГӨЖҮҮЛЭН, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БҮХИЙ Л САЛБАРТ ХАРИЛЦАН АШИГТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>				
4.1. БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО: Батлан хамгаалах болон улсын хил хамгаалалтын чадавхийг дээшлүүлж, хүч, техник технологийн хүчин	4.1.1.Засгийн ажиллагааны тусгагдсан хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	газрын үйл хөтөлбөрт “Дархан хил” зорилтыг ажлыг зохион	Хил хамгаалах туслах хүчний гишүүд, орон нутгийн оршин суугчидтай хамтран хил хамгаалах ажлыг хилийн 5 застав, шалган нэвтрүүлэх пост, 16 харуулын хүч хэрэгсэлд хилийн хяналт, үйл ажиллагаа явууллаа. 2010 онд хилийн зөрчил 37,5 хувь, хулгайн гэмт хэрэг 80 хувь буурсан байна. Засаг даргын Тамгын газар, Прокурор, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Гааль, Мэргэжлийн хяналтын албадтай хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Мөн 5-7 хүний бүрэлдэхүүнтэй багийг зөрчил гарч болзошгүй цэгүүдэд сар бүрээр томилон ажиллуулж байна. Хилийн аюулгүй байдлыг хангах зорилгоор заставуудаас 89, отрядын бэлтгэл хүчнээс 22 удаагийн эрэл хайгуулын	70

<p>чадлыг сайжруулж, дайчилгааны бэлэн байдлыг ханган аюулгүй байдлыг хамгаалах нь энэ салбарын гол зорилт болно.</p>		<p>бүлгийг томилон ажиллуулж, дэглэмийн биелэлтийг шалгасан. Отрядын алба, тасгуудын дунд “Дархан хил найдвартай хамгаалалт” болзолт уралдаан зарлаж, хэсгүүдийн хариуцсан зурваст гарсан хилийн зөрчлийн судалгааг 10 жилээр гарган дүгнэлт хийж, зохих арга хэмжээг авч ажиллаж байна.</p>	
	<p>4.1.2.Зэвсэгт хүчин, бусад цэргийн зайлшгүй шаардлагатай хүн хүч, бүтээгдэхүүнээр хангах тухай Засгийн газрын захиалгат даалгаврыг биелүүлнэ.</p>	<p>Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлж Зэвсэгт хүчний анги салбаруудыг хүн техникээр нөхөн хангах төлөвлөгөөнд улирал бүр тодотгол хийж мөрдлөг болгон хэрэгжүүлэв. Дайчилгааны төлөвлөгөөтэй уялдуулан оногдуулан даслалтыг бүрэн хийж анги командуудтай харилцан ажиллаж байна. Мөн улсын дайчилгааны мэргэжилтэн удирдамжийн дагуу албан газруудаар бүх тооцоо судалгааг гаргуулж, 24 сумтай төлөвлөгөөний тодотголыг хийж хэвшсэн нь Засгийн газрын захиалга даалгаврыг биелүүлэх боломжтой боллоо. Улсын дайчилгааны төлөвлөгөөнд тодотгол хийхэд Цэргийн штабаас мэргэжлийн туслалцаа байнга үзүүлж байна.</p>	<p>90</p>
	<p>4.1.3.Аймгийн дайчилгааны төлөвлөгөөнд улирал бүр тодотгол хийж, иргэний хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулж мөрдөнө.</p>	<p>Бүх сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нартай 2009, 2010 оны 2, 4-р улиралд Цэргийн штабаас 1, 3-р улиралд Засаг даргын Тамгын газрын дарга нар Цэргийн штабтай харилцан тодотгол хийв. Иргэний хамгаалалтын төлөвлөгөөнд улирал бүр тодотгол хийж төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тусгай төлөвлөгөө гарган холбогдох газар мэргэжлийн ангиудад хүргүүлэн харилцан ажиллаж байна.</p>	<p>90</p>
	<p>4.1.4.Сумдын дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, зориулалтаар сургалтын шинэ байрыг аймгийн Батлан хамгаалах туслах нийгэмлэгийг түшиглэн байгуулна.</p>	<p>Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх байртай болох талаар 2 сая төгрөг тусгагдсан. Аймгийн Засаг даргын 2009 оны 1 сарын 27-ны өдрийн 17 дугаар захирамжаар тус асуудлын талаар үнэлэлт дүгнэлт гаргах үнэлгээний хороо байгуулагдсан. Байрны асуудал шийдэгдээгүй</p>	<p>30</p>
	<p>4.1.5.Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн “байлдааны болон олон талт үүрэг гүйцэтгэх томилгоот бүлэг”-ийг үүрэг гүйцэтгэхэд тодорхой тусламж дэмжлэг үзүүлж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл</p>	<p>Онцгой байдал үүссэн үед гамшиг ослыг арилгахад оролцох томилгоот бүрэлдэхүүний ажиллах нөхцлийг сайжруулахад зориулж бие бүрэлдэхүүнийг дулаан хувцас ажлын багаж хэрэгслээр хангав. Тусгай томилгоот бүрэлдэхүүний сургалт, үүрэг гүйцэтгэх нөхцөл бололцоог хангахад анги, байгууллагын удирдлагатай хамтарч ажиллаа.</p>	<p>70</p>

	бололцоог бүрдүүлэхэд анхаарч ажиллана.			
	4.1.6.Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн офицер, ахлагч, ажилчдын ар гэрийг ажлын байраар хангах, орон сууц барихад газар олгох, зээл тусламжид хамруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Улиастай сумын Чигэстэй багийн нутаг дэвсгэрт орон сууц барих, 1.5 га газрын зөвшөөрлийг авснаар Зэвсэгт хүчний 325-р ангиас офицер, ахлагч, ажилчид хувийн хашаа барих нөхцөлөөр хангагдлаа. Мөн 8 айлын орон сууц ашиглалтанд орсон.	70	
4.2.ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОДЛОГО: Хил залгаа улс орны зарим муж хотуудтай болон Азийн зарим улс оронтой худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёл ба хилийн асуудлаар хамтран ажиллаж, гадаад харилцааг өргөжүүлж ажиллана.	4.2.1.Гадаад харилцааг өргөжүүлэн Оросын Холбооны улс, Бүгд Найрамдах Хятад улс, Бүгд найрамдах Солонгос улс болон бусад оронтой тогтоосон харилцаагаа улам үр дүнтэй болгож, эдийн засаг, нийгмийн салбарт хамтран ажиллана.	ОХУ-ын БНТыва улсын Засгийн газрын тэргүүн Каро-Оол Шалбон Валерьевичтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, цаашид мал хөлөөр нь гаргах, мах экспортлох, оюутан солилцох зэрэг асуудлаар хамтран ажиллахаар боллоо. Үүний үр дүнд 2009 онд 4000 бог малыг нэг бүрийг 40-50.0 мянган төгрөгөөр ОХУ-ын Тыва улсруу хөлөөр нь гаргалаа. Мөн БНСолонгос улстай хамтын ажиллагаагаа өргөжүүлсний дүнд манай аймагт 150 ширхэг компьютерийн буцалтгүй тусламж үзүүллээ. Тус улсаас манай аймагт “Цөлжилттэй тэмцэх-цөлд тэсвэртэй ургамалыг нутагшуулах” 10 сая долларын өртөгтэй төслийг хэрэгжүүлж байна.	70	
	4.2.2.Аймаг орон нутгийг гадаад орнуудад сурталчлан таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Бүгд Найрамдах Тыва улсын Засгийн газрын тэргүүнтэй байгуулсан гэрээнд Завхан аймаг болон Тыва улсын соёлын өдөрүүдийг харилцан зохион байгуулахаар тусгалаа. Мөн Бүгд найрамдах Солонгос улсад аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч тэргүүтэй төлөөлөгчид айлчлах үедээ “Улсаан” хотод “Нутгийн салхи” өдөрлөгийг зохион байгууллаа. Тус өдөрлөгт МУГЖ С.Батсүх, Классик жем зэрэг хамтлаг, уран бүтээлчид оролцлоо.		70
	<b>ДҮН</b>			<b>75,1</b>
<b>ХЭРЭГЖИЛТ</b>			<b>70,2</b>	

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ /2009-2012/

Үйл ажиллагааны чиглэл	Дэвшүүлсэн зорилт	ҮҮНЭЭС				Биелэлтийн хувь
		Бүрэн хэрэгжсэн	Хэрэгжих шатандаа	Биелэлт удааширч буй	Хугацаа хүлээгдэж буй болон тасарсан	
Эрүүл мэндийн бодлого	21	5	16			72,9
Боловсрол, соёлын бодлого	25	12	10	3		71,6
Нийгмийн хамгаалал, хүн ам зүйн бодлого	28	7	19	1	1	67,5
Үйлдвэржүүлэлтийн бодлого	8		7	1		62,5
Хүнсний аюулгүй байдал, худалдаа, үйлчилгээний бодлого	13	3	9	1		76,7
Дэд бүтэц, хот байгуулалтын бодлого	21	5	5	9	2	41,0
Хөдөө аж аухйн бодлого	14	1	10	3		57,4
Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах бодлого	15		13	2		58,0
Төсөв, санхүүгийн бодлого	11	2	9			71,4
Эрх зүйн бодлого	20	9	10	1		77,0
Иргэний нийгэм, төрийн удирдлагын бодлого	12	1	11			71,2
Батлан хамгаалах бодлого	6	2	3	1		75,0
Гадаад харилцаа, хамтын ажиллагааны бодлого	2		2			70,0
<b>НИЙТ ДҮН</b>	<b>196</b>	<b>47</b>	<b>124</b>	<b>22</b>	<b>3</b>	<b>70,2</b>